

## ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГС.....	2
ОРШИЛ.....	3
НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....	4
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	12
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	17
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ ....	19
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	19
ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	33
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	35
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	36
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	38
9.1. ЗОРИЛГО.....	38
9.2. ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧИН .....	38
9.2.1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ .....	38
9.2.2. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, САЙДЫН ТУШААЛААС.....	42
9.2.4. НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БА МЕНЕЖМЕНТИЙН ХЯНАЛТ.....	43
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	47
АРВАН НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ, ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ .....	51
АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	54
АРВАН ГУРАВ. БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДАЛ .....	56
НОМ ЗҮЙ.....	57
ХАВСРАЛТУУД.....	58

## ТОВЧИЛСОН ҮГС

АХБ	Азийн Хөгжлийн Банк
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
ОХШХ	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж

## ОРШФИЛ

АХБ-ны санхүүжилтээр ХХААХҮЯ-аас хэрэгжүүлж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслийн хүрээнд уг услалтын системийн барилга байгууламжийг шинэчлэх, сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэхээр болсон байна.

Энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь (БОМТ) цэвэр усны хангамжийн системийн барилгын ажлын үед байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, түүнд шаардагдах зардал, хяналт зэргийг багтаасан байгаль орчны дагаж мөрдөх гол бичиг баримт юм.

Тус БОМТ нь сөрөг нөлөө, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, багасгах, эсвэл зайлсхийх зорилгоор барилгын ажлын өмнө, барилгын ажлын үед байгаль орчныг хамгаалах ажлуудыг үргэлжлүүлэн сайжруулахыг чармайх юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

- ✓ Байгаль орчинд халгүй үйл ажиллагаа явуулах бүхий л боломжийг мэргэжлийн зөвлөлтэй хамтран төлөвлөх
- ✓ Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд барилгын ажлын үед хэрэгжих төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах бодит арга хэмжээг төлөвлөж, түүнийг хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагааг тодорхойлох
- ✓ Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах тал дээр анхаарч ажиллах, энэ талаар бүх ажилчдад сургалт явуулах зэрэг болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2019 оны 10-р сарын 29-ны өдөр БОАЖЯ-ны сайдын баталсан А/618 тоот “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д нийцүүлэн боловсруулав.

Улаан дэл услалтын системийн байгууламжийн барилгын ажлын БОМТ-г хэрэгжүүлэхэд нийт **31 530 000** (гучин нэгэн сая таван зуун гучин мянган) төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

БОМТ нь нийт 13 бүлэг, төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд тэдгээрийг бууруулах арга зам, зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хавсралт зэргийг агуулсан 58 хуудастай болно.

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

### ТӨСЛИЙН НЭР

#### Улаан дэл услалтын систем.

Улаан дэлийн услалтын систем нь 1980 онд байгуулагдсан, Баян-Өлгий аймгийн Сагсай сумын баруун талд байрлах бөгөөд нийт усалгааны талбай нь Сагсай сумын ЗДТГ-ын эзэмшилд байдаг. Тус услалтын системийн зураг төслийг 1974 онд Монгол Улсын Усны аж ахуйн яамны харьяа Усны хайгуул, төсөл, эрдэм шинжилгээний институтэд боловсруулж байжээ. Сагсай голоос толгойн барилга, хуваарилах байгууламж, ил сувгаар усаа татаж талбайн голоор болон баруун захаар байрлах нийт 8.8 км урт 2 хуваарилах сувгаар талбайг 110 м зайтай хуваасан түр сувгаар хуучин ЗХУ-д үйлдвэрлэсэн DDA-100МА маркийн шугаман бороожуулах машинаар усалгаа хийдэг байв. Нийт 93 га-д усалгаатай тариалалт хийж байсан байна. Уг системийн барилга байгууламжууд нь ихээхэн эвдэрч муудсан бөгөөд бүрэн шинэчлэх шаардлагатай болсон байна. Одоогоор услалтын системийн талбайд ямар нэгэн үйл ажиллагаа явуулахгүй байгаа. Орон нутгийн зарим иргэд тус услалтын системийн толгойн барилга нь эвдрэлтэй хэдий ч гол сувгаар дамжуулан хадлангийн талбайг усжуулан, зөвшөөрөлгүй ашиглаж байна.

#### АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ:

Улаан дэл услалтын систем 400 га талбайд усалгаа хийх хүчин чадалтай байхаар төлөвлөсөн ба усны эх үүсвэр нь Сагсай гол бөгөөд голоос дөхүүлэх суваг, ус тохируулах хаалттай толгойн барилгаар усаа авна. Илүүдэл ус толгойн барилгаас салаалах хаях сувгаар голд нийлнэ. Толгойн барилгаас талбай хүртэл 14 метр өндөр уналттай. Сувгийн ёроол 0.7 м, трапец хэлбэртэй, хоёр хажуу налуу нь 1:1.5. Сувгийн хамгийн их хүчин чадал  $2.2 \text{ м}^3/\text{с}$  зарцуулга өнгөрүүлэх хүчин чадалтай, урсгалын хурд  $1.94 \text{ м}/\text{с}$  байхаар төлөвлөсөн.

Сагсай голоос ил сувгаар усаа татаж талбайн голоор болон баруун захаар байрлах нийт 8.8 км урт 2 хуваарилах сувагт усаа нийлүүлнэ. Талбайд нийт 5 км ус зайлуулах сувагтай. Толгойн барилгын өнгөрүүлэх хүчин чадал  $4 \text{ м}^3/\text{с}$ . Дөхүүлэх сувгийн урт 340 м байхаар төлөвлөжээ.

Услалтын системийн талбай 400 га талбайд төвийн эргэлттэй нийт 5 бороожуулах машин байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд бороожуулах машинуудыг гол сувгийн төгсгөлд байрлах усан сангаас далд шугам хоолойгоор дамжуулан насос станцаар усаа авч ашиглахаар төлөвлөж байна.

“Улаан дэл услалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**Хүснэгт 1. 2023 онд хийж гүйцэтгэх ажлын жагсаалт**

№	Ажлын нэр	Үргэлжлэх хугацаа/хон	Эхлэх өдөр	Дуусах өдөр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
<b>ГОЛ СУВГИЙН АЖИЛ /L=2530.04M/</b>		<b>63</b>	<b>2023.04.27</b>	<b>2023.06.20</b>	-	-
1	Угсармал темер бетон хавтангуудыг бэхэлгээний арматураар холбох	21	2023.04.27	2023.6.16	100тн	0.03
2	Угсармал темер бетон хавтангуудын заадсыг бетон зуурмагаар цутгах	21	2023.05.29	2023.06.18	100 м <sup>3</sup>	0.82
3	Сувгийн хажуу налуугийн бэхэлгээний ирмэгийг бэхэлж бетон цутгах	21	2023.05.31	2023.06.20	100 м <sup>3</sup>	1.3
<b>УС ДАМЖУУЛАХ ХООЛОЙН АЖИЛ /L=4926.0 м/</b>		<b>24</b>	<b>2023.06.15</b>	<b>2023.07.06</b>	-	-
7	Шуудууг буцаан гараар булах	11	2023.06.10	2023.06.21	1000 м <sup>3</sup>	0.55
8	Шуудууг механизмаар буцаан бүлж нягтруулах	8	2023.06.22	2023.06.30	100 м <sup>3</sup>	31.12
9	Ухлагаас илүү гарсан шороог ачиж 1км зайд зөөж асгах	5	2023.07.01	2023.07.06	1000 м <sup>3</sup>	3.01
<b>Дөхүүлэх сувгийн ажил /L=340/</b>		<b>27</b>	<b>2023.05.28</b>	<b>2023.06.24</b>	-	
1	Экскаватораар ухах	9	2023.05.28	2023.06.06	1000 м <sup>3</sup>	0.52
2	Сувгийн ёроолыг гараар ухаж тэгшлэх	11	2023.06.06	2023.06.17	1000 м <sup>3</sup>	0.02
3	Ухлагаас гарсан хөрсөөр овоолго хийж нягтруулах	7	2023.06.17	2023.06.24	1000 м <sup>3</sup>	0.47
<b>ХАЯХ СУВГИЙН АЖИЛ /L=1047,4M/</b>		<b>42</b>	<b>2023.07.19</b>	<b>2023.08.30</b>		
1	Экскаватораар ухах	28	2023.07.19	2023.08.16	1000 м <sup>3</sup>	0.73
2	Сувгийн ёроолыг гараар ухаж тэгшлэх	20	2023.08.01	2023.08.21	1000 м <sup>3</sup>	0.02
3	Ухлагаас гарсан хөрсөөр овоолго хийж нягтруулах	12	2023.08.18	2023.08.30	1000 м <sup>3</sup>	0.34
<b>НАСОС СТАНЦЫН АВАН КАМЕРЫН АЖИЛ</b>		<b>31</b>	<b>2023.06.11</b>	<b>2023.07.11</b>		
1	Ургамлын өнгөн хөрс хуулах t=0.3 м	2	2023.07.21	2023.07.23	100 м <sup>3</sup>	0.14
2	Экскаватораар ухах	5	2023.07.13	2023.07.18	1000 м <sup>3</sup>	0.29
3	Хөрс гараар ухаж тэгшлэх	2	2023.07.18	2023.07.20	1000 м <sup>3</sup>	0.01
4	Элсэн бэлтгэл үе хийх	1	2023.07.20	2023.07.21	100 м <sup>3</sup>	0.06
5	Бетон бэлтгэл хийх	2	2023.07.21	2023.07.23	м <sup>3</sup>	8.3
6	Аван камерын арматур байрлуулах	5	2023.07.23	2023.07.28	100тн	0.04
7	Аван камерын бетон цутгах в15	2	2023.07.28	2023.07.30	100 м <sup>3</sup>	0.8
8	Бетон гадаргууд 2 үе тусгаарлалт хийх	1	2023.07.30	2023.07.31	100 м <sup>2</sup>	0.1
9	Ажлын тавцан угсрах	7	2023.07.31	2023.08.07	тн	0.65

**“Улаан дэл услалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Ажлын нэр	Үргэлжлэх хугацаа/хон	Эхлэх өдөр	Дуусах өдөр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
10	Хаалт угсрах	3	2023.08.07	2023.08.10	1тн	0.86
11	Орох хаях хэсгийн хаалт будах	1	2023.08.10	2023.08.11	1тн	0.86
<b>НАСОС СТАНЦЫН АВАН КАМЕРЫН ГҮҮРНИЙ АЖИЛ</b>		<b>7</b>	<b>2023.08.11</b>	<b>2023.08.18</b>		
1	Насос станцын аван камерын гүүрний ажил	7	2023.08.11	2023.08.18		1
<b>НАСОС СТАНЦЫН БАРИЛГА ТЕХНОЛОГИЙН ШУГАМ ХООЛОЙН АЖИЛ</b>		<b>43</b>	<b>2023.07.18</b>	<b>2023.08.30</b>		
1	Газар шорооны ажил	2	2023.07.18	2023.07.20		
2	Суурийн ажил	3	2023.07.20	2023.07.23		
3	Шалны ажил	4	2023.07.23	2023.07.27		
4	Хана хамар ханы ажил	7	2023.07.27	2023.08.03		
5	Хаалга цонхны ажил	5	2023.08.03	2023.08.08		
6	Дээврийн ажил	4	2023.08.08	2023.08.12		
7	Насос станцын технологийн шугам хоолой холболтын ажил	13	2023.08.17	2023.08.30		
<b>БОРООЖУУЛАХ МАШИНЫ ХОЛБОХ УЗЕЛИЙН МАТЕРИАЛЫН ХОЛБОЛТЫН АЖИЛ</b>		<b>264</b>	<b>2023.08.09</b>	<b>2023.09.29</b>		
1	Экскаватораар ухах	10	2023.08.09	2023.08.19	1000 м <sup>3</sup>	0.05
2	Талбайг гараар тэгшлэх	3	2023.08.19	2023.09.21	1000 м <sup>2</sup>	0.28
3	Элсэн бэлтгэл үе хийх	2	2023.08.22	2023.09.23		0.06
4	Механизмаар буцаан булж нягтруулах	1	2023.08.25	2023.09.25	100 м <sup>3</sup>	0.04
5	Бетон тулгуурын арматур байрлуулах	5	2023.08.26	2023.09.30	100 тн	0.01
6	Бетон тулгуур цутгах в15	3	2023.08.31	2023.09.02	100 м <sup>3</sup>	0.01
<b>ҮЕРИЙН ХАМГААЛАЛТЫН СУВАГ /L=5030,25M/</b>		<b>37</b>	<b>2023.08.10</b>	<b>2023.09.15</b>		
1	Экскаватораар ухах	31	2023.08.10	2023.09.09	1000 м <sup>3</sup>	7.4
2	Сувгийн ёроолыг гараар ухаж тэгшлэх	27	2023.08.20	2023.09.15	1000 м <sup>3</sup>	0.23
3	Ухлагаас гарсан хөрсөөр овоолго хийж нягтруулах	7	2023.08.30	2023.09.05	1000 м <sup>3</sup>	3.39
<b>УСАН САНГИЙН ХАЯХ СУВГИЙН АЖИЛ /L=5290.00M</b>		<b>71</b>	<b>2023.06.12</b>	<b>2023.07.21</b>		
1	III зэргийн хөрс экскаватораар ухах	37	2023.06.12	2023.07.18	1000 м <sup>3</sup>	2.48
2	Сувгийн ёроолыг гараар ухаж тэгшлэх	20	2023.06.19	2023.07.07	1000 м <sup>3</sup>	0.08
3	Ухлагаас гарсан хөрсөөр овоолго хийж нягтруулах	7	2023.06.08	2023.07.14	1000 м <sup>3</sup>	3.31
4	Овоолгод дутсан шороо зөөж авчрах	7	2023.06.15	2023.07.21	1000 м <sup>3</sup>	0.75

**“Улаан дэл услалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**


№	Ажлын нэр	Үргэлжлэх хугацаа/хон	Эхлэх өдөр	Дуусах өдөр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
	<b>ХАЯХ СУВГИЙН ГҮҮРНИЙ АЖИЛ</b>	<b>8</b>	<b>2023.06.29</b>	<b>2023.07.06</b>		
1	Двутавр угсрах №20	2	2023.06.29	2023.06.31	тн	0.19
2	Булан төмөр угсрах 50x50x5,0мм	2	2023.06.31	2023.07.02	тн	0.03
3	Металл лист угсрах	2	2023.06.02	2023.07.04	тн	0.18
4	Ган бүтээц будах	2	2023.06.04	2023.07.06	тн	0.41
	<b>ГҮҮРНИЙ АЖИЛ</b>	<b>25</b>	<b>2023.05.06</b>	<b>2023.06.31</b>		
1	Хуучин гүүр задалж буулгах	2	2023.05.06	2023.06.08	м <sup>3</sup>	6
2	Буулгасан гүүрний хаягдал бетоныг ачиж зайлуулах	2	2023.05.08	2023.06.10	м <sup>3</sup>	6
3	Гүүрийн тулгуурын нүх экскаватораар ухах	2	2023.05.10	2023.06.12	1000 м <sup>3</sup>	0.01
4	Элсэн бэлтгэл үе хийх	1	2023.05.12	2023.06.13	100 м <sup>3</sup>	0.01
5	Бетон тулгуурын арматур байрлуулах	4	2023.05.13	2023.06.17	100 тн	0
6	Бетон тулгуур цутгах в15	2	2023.05.17	2023.06.19	100 м <sup>3</sup>	0.07
7	Ухлагаас гарсан хөрсөөр булж нягтруулах	2	2023.05.19	2023.06.21	100 м <sup>3</sup>	0.04
8	Бетон гүүрний хавтангийн арматур байрлуулах	2	2023.05.21	2023.06.23	100 тн	0.01
9	Бетон гүүрний хавтан цутгах в15	2	2023.05.23	2023.06.25	100 м <sup>3</sup>	0.02
10	Төмөр хашлаганы хийцийн бэлдэц бэлтгэх	2	2023.05.25	2023.06.27	тн	0.28
11	Гүүрний хашлага угсрах	2	2023.05.27	2023.06.29	тн	0.28
12	Ган хайс будах	2	2023.05.29	2023.06.31	тн	0.28
	<b>Услалтын системийн тоног төхөөрөмж худалдан авалт</b>	60	2023.04.03	2023.06.01		0
	<b>Услалтын системийн тоног төхөөрөмж суурилуулалт, тохируулга</b>	55	2023.08.01	2023.09.27		0
	<b>Бороожуулах машины холбох үзелийн материалын холболтын ажил</b>	19	2023.08.07	2023.08.25		0
1	Ган яндан хоолойд фланц гагнах d=150мм	3	2023.08.07	2023.08.09	ш	10
2	Ган отвод гагнах d=150мм	2	2023.08.10	2023.08.11	ш	10
3	Ган шилжвэр угсрах d=150*200мм	2	2023.08.12	2023.08.13	ш	5
4	Ган богино хоолой угсрах голч d=150мм	2	2023.08.14	2023.08.15	км	0.02
5	Ган богино хоолой угсрах d=200мм	2	2023.08.16	2023.08.17	км	0.01
6	Ган хаалт тавих, хаалтын голч d=150мм	2	2023.08.18	2023.08.19	ш	5
7	Муфт угсрах d=150мм	2	2023.08.20	2023.08.21	ш	5
8	Даралт тохируулах хаалт угсрах д150	2	2023.08.22	2023.08.23	ш	5
9	Ган гуравдагч угсрах d=250*400мм	2	2023.08.24	2023.08.25	ш	5

**“Улаан дэл усралтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Ажлын нэр	Үргэлжлэх хугацаа/хон	Эхлэх өдөр	Дуусах өдөр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
<b>Талбайн тэгшилгээний ажил</b>		<b>17</b>	<b>2023.08.28</b>	<b>2023.09.13</b>		
1	Талбайн чулууг түүж, цуглуулж зөөх	7	2023.08.28	2023.09.03	1м <sup>3</sup>	1.7
2	Илүүдэл шороог механизмаар тараан тэгшлэх	10	2023.09.04	2023.09.13	100м <sup>3</sup>	18.4
<b>Ногоон байгууламжийн ажил /мод тарих/</b>		<b>14</b>	<b>2023.10.14</b>	<b>2023.10.27</b>		
1	Ойн зурвас байгуулахад зориулсан мод, бут сөөг суулгах нүхийг гараар ухаж бэлтгэх	5	2023.10.14	2023.10.18	1м <sup>3</sup>	377
2	Модны суулгац суулгах	8	2023.10.17	2023.10.24	ш	1250
3	Бут сөөгийн суулгац суулгах	5	2023.10.23	2023.10.27	ш	250



“Улаан дэл усгалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 1. Ерөнхий төлөвлөгөө

Хэрэгжүүлэлт эхлэх огноо: 2023 оны 04-р сар

Төсөл хэрэгжилт дуусахаар төлөвлөж буй огноо: 2023 оны 11 дугаар сар

Хариуцаж буй байгууллагуудын нэр хаяг

Захиалагч: Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам


Санхүүжилтийн эх үүсвэр: Азийн хөгжлийн Банк (АХБ)

Гүйцэтгэгч байгууллагын товч мэдээлэл:

№	Үзүүлэлтүүд	Мэдээлэл	
1	Төслийн нэр	“Улаан дэл услалтын систем”	
2	Гүйцэтгэгч аж ахуйн нэр	“Эс энд Эй трейд” ХХК	
3	Улсын бүртгэлийн дугаар	9011134073	
4	Талбайн байршил	Баян-Өлгий аймаг, Сагсай сум	
5	Барилгын ажлын үргэлжлэх хугацаа	----	
6	“Эс энд Эй трейд” ХХК-ийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
		Сум/Дүүрэг	Чингэлтэй
		Баг/Хороо	1
		Гудамж/Байр	
		Утас/Факс	11319005
		Гар утас	99116267
		Электрон шуудан	s_and_a99@yahoo.com
7	Хариуцах ажилтан	Албан тушаал	Ерөнхий инженер
		Нэр	Сүхбаатар
		Утас	99110233
		Албан тушаал	Байгаль орчны мэргэжилтэн
		Нэр	С. Түмэннаст
		Утас	88085806

**ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙРЛАЛ:**

“Улаан дэл” услалтын систем нь Улаанбаатар хотоос 1672 км, аймгийн төвөөс 28 км зайтай оршдог бөгөөд өөрийн аймгийн Өлгий хот, Улаанхус, Цэнгэл, Буянт, Алтай сум болон БНХАУ-тай хиллэдэг.



Зураг 2. Төслийн талбайн байршил

## ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

**Газрын гадарга, физик газарзүйн нөхцөл:** Төслийн талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалтаар Алтайн уулархаг их муж, Монгол Алтайн мужын Монгол Алтайн баруун тойрогт хамаарагдана

Геологийн тогтоцын хувьд Монгол Улсын ашигт малтмалын зургаас үзэхэд Ховд голын савд орчин үеийн дөрөвдөгчийн (Голоцений) аллюви, делюви, мөстлөг, нуур, салхины гаралтай сэвсгэр хурдас зонхилж, Палеозойн настай хувирмал, тунамал, бялхмал чулуулаг, тэдгээрийн хослол, тунамал-хувирмал, тунамал-бялхмал, тунамал-бялхмалхувирмал гаралтай үндсэн чулуулаг, түүнчлэн Палеозойн эринд үүссэн түрмэл чулуулаг өргөн тархжээ. Монгол Алтай нуруунд гүний, бүсийн, орон нутгийн гаралтай тектоник олон хагарал бий. Төслийн талбайд дөрөвдөгчийн (Q4) болон Неогений-дунд плиоцены (Q2) хурдас тархсан байна.

Судалгааны нийт талбай нь Сагсай голын хөндийд байрлах бөгөөд урдаасаа хойш ялимгүй хэвгий тогтоцтой талбайд Уулт-Атираат өргөгдлийн элэгдэл тектоникийн гаралтай гадарга (N-Q)-ын Их хэрчигдсэн, эгц хажуутай уул, нуруу бүхий хэсэгт байрлана.

**Уур амьсгал:** Баян-Өлгий аймагт дунджаар 11 дүгээр сарын эхээр өвөл эхэлж, 3 дугаар сарын 2 дугаар хагаст шувтарч 227-236 хоног үргэлжилнэ. Ийнхүү өвлийн улиралд 11, 12, 1, 2 дугаар сар бүтнээрээ, 3 дугаар сарын хагас хамаарагдах тул эдгээр сарын уур амьсгалын үзүүлэлтээр өвлийн цаг уур тодорхойлогддог ажээ.

Хаврын улирал хоногийн дундаж температур  $-5^{\circ}$ -ийн заагийг давж дулаарснаас хойш  $+10^{\circ}$ С-ийн заагийг хүрэх хүртэлх үеийг хамаардаг ба тус нурууны хэмжээнд дунджаар 3 дугаар сарын 15-20-ны үеэс хавар эхлэн 5 дугаар сарын 1-7-ыг хүртэл 45-50 хоног үргэлжилнэ. Нэгэнт 4 дүгээр сар бүтнээрээ, 5 дугаар сарын эхний арав хоног хамаарагдаж байгаа тул энэ үеийн цаг агаарын байдлаар хаврын улирлын шинжтэй байдаг ба хаврын сүүлч үед 5 дугаар сарын эхний хагасыг судлаачид хамааруулдаг байна.

Зуны улирал хоногийн дундаж агаарын температур  $+10^{\circ}$ С-аас дулаан байх үеийг хэлдэг ба тус аймгийн хувьд 5 дугаар сарын хоёрдугаар арав хоногоос зуны улирал эхэлж 9 дүгээр сарын дундуур шувтарч 132-142 хоног үргэлжилнэ. Иймд зуны улиралд 5 дугаар сарын 2 дугаар хагас, 6, 7, 8 дугаар сар бүтнээрээ, 9 дүгээр сарын эхний хагас хамаарагдаж, улмаар хур тунадас их ордог, хамгийн дулаан ургамлын вегетацийн хугацаа явж өнгөрөх тааламжтай үе болно.

Намрын улирал хоногийн дундаж агаарын температур  $+10^{\circ}$ С-ын заагийг давж сэрүүсэх үеэс эхэлж, өвлийн сартай залгах үе хамаарагдах ба энэ нь тус нурууны системд 9 дүгээр сарын 16-19-ний үеэс эхэлж 11 дүгээр сарын эх 2-7-ны орчим хүртэл 50-55 хоног үргэлжилнэ.

Тус аймгийн нутгаар агаар хуурай болохоор хур тунадасны хэмжээ ч нийтдээ бага. Далайн түвшнээс дээш 1000- 1500 м өргөгдсөн Ховд голын хөндийд 50-90 мм, дулааны улиралд 40-70 мм хур тунадас тус тус унадаг ба ялангуяа өндөр ууландаа жилийн 188-200 хоногт цасан бүрхүүлтэй байна. Жилийн дундаж хур тунадас Өлгий станцын мэдээгээр 109 мм байхад, Даян станцын мэдээгээр авч үзэхэд зөвхөн зуны 5-9 дүгээр сарын хооронд 150- 160 мм хур тунадас ордог. Энэхүү зүй тогтол бусад станцуудын мэдээнээс үзэхэд их бага хэмжээгээр давтагддаг байна.

Салхины горим нь агаар мандлын орчил урсгал, тухайн орон нутгийн дулаан баланс уул зүйн онцлогоос шалтгаална. Тус сумын нутгийн уул зүйн тогтоц нутгийн хотгор, гүдгэр нь салхины оронд ихээхэн нөлөөлнө. Мөн агаар мандал дахь процессоо дагаж өвөл, зуны салхины чиглэлийн давтагдал хоорондоо нэлээд ялгаатай. Жилийн салхины дундаж хурд нь 2.7-5.1 м/с ба ялангуяа хавар намар салхи ихтэй, өндөр ууландаа жилд 45, бусад нутгаар 30 хүртэл удаа шороон ба цасан шуурга шуурдаг.

**Агаарын чанар:** Төслийн талбайн агаарын чанарыг 2020 оны 12 дугаар 3-ны өдөр талбайд Баян-Өлгий аймгийн Ус, Цаг уур орчны шинжилгээний төвийн мэргэжилтнүүд агаарын чанарын хяналтын 2 цэг (АЧХЦ) сонгож орчны агаарт агуулагдах түгээмэл бохирдуулагчид болох Хүхэрлэг хий (SO<sub>2</sub>), Азотын давхар исэл (NO<sub>2</sub>), нийт тоосонцрын (TSP) нэг удаагийн хэмжилт хийхэд нийт тоос, хүхэрлэг хий болон азотын давхар ислийн агууламж нь “Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016”-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу бохирдолгүй байна.

**Гадаргын ус:** Монгол орны гол, мөрөн, түүний сав газрын хэмжээ, байгалийн нөхцөл, урсац бүрэлдэх зүй тогтол, нөөцийн хуваарьлалт, байгалийн болон засаг захиргааны хил хязгаарыг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 332 дугаар тушаалаар Монгол орны нутаг дэвсгэрийг усны 29 сав газарт хувааж, хил хязгаарыг нь тогтоож өгсөн байдаг бөгөөд тус төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Хар нуур-Ховд голын сав газарт хамаарна.

Сагсай голын сав газар нь нийтдээ өндөр уулын бүсэд багтдаг, Ховд голд цутгах үедээ хэд салаалж өргөн тэгш хөндий болдог. Услалтын системийн услагдах талбайгаас 30 км-т орших Өлгий станцын уур амьсгалын өгөгдлүүдийг ашиглан уур амьсгалын доорх тооцоог хийв. Сагсай голын ёроол хайр, хад чулуун хурдастай голын ёроолын ерөнхий уналт их түргэн урсгалтай гол юм. Мөс цасны болон зуны хур борооны усаар тэжээгддэг олон жижиг голууд Сагсай голд цутгана. Сагсай голын хамгийн их зарцуулга нь шар ус, хур борооны устай холимог ажиглагдана. 5-р сарын эхнээс усны түвшин аажим ихсэж 6-р сарын сүүлч 7-р сарын эхээр хамгийн их түвшин ажиглагдана. Хамгийн их өнгөрөлтийн параметруудийг Сагсай гол дээрх Буянт сумын дэргэдэх ус хэмжих харуулын 1998-2018 онуудын олон жилийн ажиглалтын материалыг үндэслэн



тооцов. Гэвч ус авах толгойн барилгын створ нь Буянт харуулаас 25 км доор, ус хураах талбай нь 375 км<sup>2</sup> -аар их юм.

#### **Гадаргын усны чанар.**

Сагсай голын ус нь гидрокарбонатын ангийн ус байна. Гидрокарбонатын ангид бага эрдэсжилттэй гол, нуурууд ордог бөгөөд усны катион нь кальцийн, магнийн, натрийн мөн холимог байж болно. О.А.Алекины ангиллын анги бүрт катионы зонхилох кальци (Ca<sup>2+</sup>), магни (Mg<sup>2+</sup>), натри (Na<sup>+</sup>)-ийн хэсэг хамаарагддаг бөгөөд төрлөөр нь 1, 2, 3, 4-р төрлийн ус гэж 4 ангилдаг. Төсөл хэрэгжих орчны гадаргын ус нь хоёрдугаар төрлийн ус байна. Усны рН-ийн өөрчлөлт нь бусад химийн өөрчлөлтийг бий болгож усан орчин дахь амьдралд шууд бус байдлаар нөлөөлдөг бөгөөд Сагсай голын ус нь сул шүлтлэг ус байна. Мөн усны хатуулгаар усны чанарт үнэлгээ өгсөн ба энэ үзүүлэлт нь усанд ууссан кальци (Ca<sup>2+</sup>), магни (Mg<sup>2+</sup>)-н ионы агууламжийн нийлбэрийг мг-экв/л-ээр илэрхийлснийг хэлэх бөгөөд төмөр (Fe<sup>2+</sup>), манган (Mn<sup>2+</sup>)-ыг оруулж үзэх тохиолдол байдаг. Төсөл хэрэгжих орчны голын ус нь зөөлөн ус байна

**Газрын доорх ус:** Өлгий хотын ус хангамж, Буянт голын садраа адаг ба Ховд хотын ус хангамжийн эх үүсвэр болох аллювийн хурдас дахь газар доорх ус сайн судлагдсан бөгөөд нийт 70.8 ам км талбайд 11.2 сая шоо м/жил нөөцтэй, судалгааны түвшин харьцангуй доогуур байгаа 18892.9 ам км талбайд тархсан аллювийн хурдас дахь тасалданги цэвдэг бүхий ус агуулагч нүх сүвэрхэг бүрдэл болон бусад нүх сүвэрхэг бүрдэлд 1490.2 сая шоо м/жил (1.451 шоо км/жил) усны нөөцтэй байна. Хар нуур-Ховд голын сав газрын 53.1 хувийг эзэлж буй хатуу үндсэн чулуулгууд дахь ус агуулагч ан цавлаг бүсэд газар доорх усны нийт нөөцийн дөнгөж 1.7 хувь (29.7 сая шоо м/жил буюу 0.0291 шоо км/ жил) ногдож байна. Энэ нь газар доорх усны тархац нэн жигд бус бөгөөд нөөц нь хязгаарлагдмал болохыг харуулж байна. Газар доорх усны ашиглалтын нөөцийг гидрогеологийн нарийвчилсан судалгаагаар тогтоосон 6 орд Хар нуур-Ховд усны голын савд бий. Харин гидрогеологийн Баруун системийн хэмжээнд газар доорх усны ашиглалтын нөөцийг тодорхойлсон 20 орд байна. Баруун Монголд 54 сав, үүний дотор ул хөрсний ус зонхилж тархсан 6 сав, уулс доторх артезийн ус тархсан 18 сав, уулс хоорондын артезийн, дутуу артезийн 30 сав байдаг. Газар доорх усны нөөцийг Хар нуур- Ховд голын сав газар, үүний дотор ус ашиглалтын балансын 3 нэгж, түүн дэх сумдын нутгаар тодорхойлоход (Н.Жадамбаа, 2010) Буянт голын савд 0.139 км<sup>3</sup> /жил, Ховд голын савд 0.786 км<sup>3</sup> /жил ба Хар Ус-Дөргөн нуурын өмнөд сав газарт 0.423 км<sup>3</sup> /жил байна. Газар доорх усны харьцангуй элбэг нөөцтэй нь Цэнгэл, Улаанхус, Ногооннуур сум ба бусад сумдад харьцангуй бага, ялангуяа, Буянт голын савд Дэлүүн сумаас бусад нь багавтар нөөцтэй байна.

**Хөрсөн бүрхэвч:** Сагсай услалтын системийн төслийн тариалангийн талбайд элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй чулуурхаг Цайвар хүрэн хөрс зонхилж, маш бага хэмжээгээр хужирлаг хөрс

тархсан байна. Услалтын системийн талбайд бүхэлд нь тархсан Цайвар хүрэн хөрсний ялзмагт үеийн зузаан дунджаар 30-32 см байна. Ялмагийн агууламж ихэнх үе давхарга нь 2 %-иас бага байгаа нь ялмагийн хэмжээ их бишийг харуулж байна. Гэхдээ 50-60 см хүртлэх үе давхаргийн ялмагийн хэмжээ 1.44-2.54 % хооронд байгаа нь үржил шимт үе давхарга зузаан байгааг мөн гэрчилж байна. Хөрсний урвалын орчин дунд зэрэг шүлтлэг. Карбонатын хуримтлал бага, зарим хөрсөнд огт байхгүй. Ургамлын үндэс зонхилон тархах ялмагт үедээ нитрат азотын агууламж бүх төрлийн тарималд маш бага хангалттай байгаа бол хөдөлгөөнт фосфор үр тарианд багаас дунд зэрэг, төмсөнд бага, хүнсний ногоонд маш бага хангалттай, солилцох кали үр тарианы ургамалд багаас дунд зэрэг, төмс, хүнсний ногоонд маш бага хангалттай байна. Хөрсний бүх үе давхаргыг хамруулан авч үзэхэд нягт (эзлэхүүн жин 1.58-1.78 г/см<sup>3</sup>), сүвшилт бага (26-35 %) байна. Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний хувьд элсэнцэрээс элсэн механик бүрэлдэхүүнтэй. Энэ хөрс нь маш их нягтарсан бүтэц муутайн дээр том ширхэгүүдийн эзлэх хувь өндөр байна. Мөн хөрсний гадаргуу болон профилийн бүх л үе давхаргад янз бүрийн хэмжээтэй чулууны агууламж ихтэй байгаа нь хөрс нь ус барих чадвараар маш муу, ус нэврүүлэх чадвар ихтэй байхын зэрэгцээ чулууны агууламж их байгаа нь усалгаатай газар тариаланд ашиглахад олон талын сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай болно. Нийт талбайн хэмжээнд хүчтэй эвдэрсэн хөрстэй газар байхгүй, харин зарим газартаа өнгөн хөрс халцгай болсон, усалгааны нөлөөгөөр өнгөн хөрсний давсжилт нэмэгдэх, бэлчээр болон ердийн шороон замаар талхагдах зэргээр хөрсөн бүрхэвч дунд зэрэг доройтолд орсон байна. Үндсэн ба туслах шуудууны нөлөөгөөр эвдэрсэн талбай 18 га орчим буюу нийт төслийн талбайн 4 % орчим болж байна. Хуучин услалтын системийг ашиглаж байх үед 400 хүртэлх га талбайд тариалж байсан. Одоо ойролцоогоор 220 га талбайг ашиглаж байна. Усалгааны үндсэн ба туслах шуудуунд өртөж эвдэрсэн 18 га газар байна. Судалгааны талбайн хэмжээнд хүнд металлын ямар нэгэн аномаль (гажиг) агууламж байхгүй буюу бохирдолгүй байна.

**Ургамлан бүрхэвч:** Баян- Өлгий аймгийн Сагсай сумын нутагт орших төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Ховдын уулын цөлжсөн хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.).

Ховд голын сав Баян-Өлгий аймгийн Сагсай сум орчимд 2020 оны 11 сард хийгдсэн судалгаагаар нийт 15 овогт хамаарах 31 төрөл, 51 зүйл ургамал бүртгэгдсэн. Ургамлыг ангилвал хамгийн олон төрөлтэй овог нь Ниймэлцэцэгтний овог 6 төрөл, 10 зүйлтэй, Луулийн овог 6 төрөл, 6 зүйлтэй, Үетний овог 7 төрөл, 8 зүйлтэй, Буурцагтны овог 4 төрөл, 6 зүйлтэй, сонгинтоны овог, Сарнайн овог 1 төрөл, 3 зүйлтэй байцааны овог 2 төрөл, 2 зүйлтэй, Улалжын овог, авансалааны овог 1 төрөл, 2 зүйлтэй бусад овогууд нь тус бүр нэг төрөл нэг зүйлтэй. Мөн хамгийн их зүйлтэй төрөл нь Шарилжийн төрөл 5 зүйл, луулийн төрөл 4 зүйл, Гичгэнэний төрөл

3 зүйл, Сонгины төрөл 3 зүйл, Харгана, хунчир, улалж, тавансалаа, хялгана, хависганы төрөл тус бүр 2 зүйлтэй бөгөөд бусад төрлүүд нэг нэг зүйлтэй.

Монгол Алтайн нурууны баруун хойд хэсгийн өндөр уулс нь Бушилзат, улалжит хүйтсэг нуга, хүйтсүү – хуурайсаг алаг өвс, жижиг дэгнүүлт хүйтсэг хээр болон хаг- хөвдөт тундрын ургамалжилтай. Уулсын энгэр, хажууг дагаж хуурай хээрийн ургамалжилт нилээн өгсөж тархдаг. Бэсрэг уулсын ар, хажууг дагаж ботуульт, ботууль -жижг дэгнүүлт үетэнт, үетэн – алаг өвст, уулын бэл хаяагаар хялгана -жижиг дэгнүүлт үетэнт, агь- өдлөг хялганат хээртэй. Голын хөндийг дагасан чацаргана, өргөст харганы ширэнгэ, хус, улиасан төгөлтэй. Хоион, Хурган нуур, Цэнгэл хайрхан голуудын эхний өндөрлөгүүдэд шинэсэн ойтой. Талархаг газраараа өдлөг хялгана – бударганат, өдлөг хялганат, таана өдлөг хялганат, заримдаг сөөгөнцөр – өдлөг хялганат цөлийн хээрийн ургамалжилтай.

**Амьтны аймаг:** Судалгааны материалаас үзэхэд Хар нуур – Ховд голын сав газар биологийн олон янз байдлын хувьд ихээхэн онцлогтой байна. Тухайлбал үндэсний болон олон улсын хэмжээнд ховор амьтдын жагсаалтад бүртгэгдсэн цөөнгүй зүйл байгаа нь бүс нутгийг экосистемийн хувьд хамгаалах, зохистой ашиглах шаардлагатайг илэрхийлж байна. Тухайлбал сав газрын хэмжээнд мөлхөгчдийн 3, загасны 3 зүйл эндемик байна. Мөн алтайн хойлог (*Tetraoglus altaicus*), өгөөлэй шулганаа (*Saxicola insignis*) зэрэг ховор шувууд бүртгэгдсэн. Биологийн олон янз байдлын энэ онцлог нь түүний амьдрах орчинтой шууд холбоотой юм. Ховд, Буянт голын сав газар нь умрын тайга, өндөр уул, төв Азийн хээр, цөлийн экосистемүүдийн уулзвар бөгөөд гол, нуурын сүлжээ сайтай.

**Нийгэм, эдийн засаг:** Баян-Өлгий аймгийн Сагсай сум нь 1959 онд байгуулагдсан, хуучнаар Ховдын хязгаарын Шеруши хошуу, одоогийн Улаанхус сумын Ялалт нэгдлээс тусгаарлагдсан. Тус сум нь Ямаат, Хол агаш, Аххорым, Хаг, Даян, Уужим, Өмнөгол гэсэн 7 багтай.

Сагсай сум нь Баян-Өлгий аймгийн баруун хэсэгт байдаг бөгөөд аймгийн төвөөс 28 км, нийслэл Улаанбаатар хотоос 1668 км хол оршдог. Өлгий хот, Улаанхус, Цэнгэл, Буянт, Алтай сум болон БНХАУ-тай хил залгадаг. Тус сум нь далайн түвшнээс дээш 1750 м өргөгдсөн. Физик газарзүйн хувьд Монгол Алтайн уулсын мужид багтдаг. Газар хөдлөлтийн эрчим 7 балл хүртэл байна. Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ, толгод бүхий Ховд, Сагсай, Турган, Ямаат, Хар чулуут, Сонгинот зэрэг том голуудтай, мөн Хар нуур, Даяннуур болон Ямаат, Сонгинот зэрэг байгалийн үзэсгэлэнт газар байдаг ба аялал жуулчлал хөгжүүлэхэд тохиромжтой. Нийт газар нутгийн хэмжээ 313999 га.

2019 оны жилийн эцсийн байдлаар Сагсай суманд 1277 өрхийн нийт 5229 хүн оршин сууж байгаа бөгөөд үүний 2623 эрэгтэй, 2606 эмэгтэй хүн байна. Тус саманд хөдөлмөрийн насны хүн 2935 байна. Нийт өрхийн 31.5 % нь сумын төвд 68.5 % нь хөдөө амьдардаг. Нийт хүн ам 15 гэрт, 1 орон сууцны байшинд, 1249 сууцны тусдаа байшин, 2 нийтийн байранд, 12 бусад сууцанд амьдардаг. Хүн амын нягтшил нь 1.7 байна.



## **ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

Улаан дэл услалтын системийн барилгын ажлын үед нийгэм, эдийн засаг, нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг БОМТ-нд тусгасан болно. “Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ”-г төлөвлөхдөө ажлын үед байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээнүүдийг төлөвлөв.

Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь барилга, угсралтын ажлын явцад үүсэхээр байна. “Эдгээр нөлөө нь ажлын талбайн хэмжээнд хязгаарлагдахаас гадна түр хугацаатай бөгөөд хүрээлэн байгаа орчны эх үүсвэрт заналхийлэх, сулруулах хэмжээтэй биш” хэмээн дүгнэж байна.

### **Төслийн гол сөрөг нөлөөлөл**

Улаан дэл услалтын системийн байгууламжийн барилгын ажилтай холбоотой гол сөрөг нөлөөллийн үнэлгээг БОНХС-ын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А/117 тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан аргачлалын дагуу болон нөлөөллийн оноот үнэлгээний аргыг хоёр янзаар тооцсон. Үүнд: Хөрс хуулалт, газар ухах, буцаан булах, шугам хоолой тавих үйл ажиллагаа тус бүрээс үзүүлэх нөлөөлөл болон байгалийн бүрэлдэхүүн бүрд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг тус тусад нь авч үзэн судалсан.

Шинээр хийгдэх газар шорооны ажлын үед буюу шугам хоолой тавих, хөрс хуулалт, газар ухах ажлын үед барилгын материал, техник, тоног төхөөрөмж зэргийг ажлын талбай дээр авчрах, бетоны хольц, хог хаягдлыг тээвэрлэх, ачих буулгах, машин техник, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хөдөлгөх үед ажлын талбайн хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг доройтох, ил задгай барилгын хог хаягдлаар бохирдох, тоос, дүү чимээний бохирдол ихсэх зэрэг түр зуурын нөлөөллүүд үүснэ.

Хүснэгт 2. Байгаль орчны бүрэлдэхүүнд тус бүрд үзүүлж болзошгүй нөлөөлөл

№	Үзүүлэлт	Нөлөөллийн түвшин	Тайлбар
1	Газрын хэвлий рельеф	Их	Ажлын үед шинээр газар ухах, суваг, шуудууны ажил хийгдэх бөгөөд энэ төрлийн нөлөөлөл их боловч барилгын ажлын дараа нөхөн сэргээгдэх бүрэн боломжтой, түр нөлөөлөл байна.
2	Цаг уур, уур амьсгал	Дунд	Цаг агаарын нөхцөл байдлаас ил барилга угсралтын ажиллагаа шууд хамааралтай байдаг бөгөөд цаг уурын таагүй байдлаас барилгын ажил зогсох, удаашрах зэргээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хугацаа уртасна. Хүчтэй салхи, шороон шуургаар ил задгай барилгын болон ажилчдын хог хаягдал хийсэж орчныг бохирдуулах зэргээр нөлөөлж болзошгүй.
3	Агаарын чанар	Бага	Газар ухах, барилгын ажил болон техник тоног төхөөрөмжийн хөдөлгөөний үйл ажиллагаанаас тоос шороо үүснэ. Барилгын талбайд ажиллах техникүүдийн түлшний шаталтаас хүлэмжийн хий ялгарна.
4	Усан орчин	Бага	Төслийн талбайн нөлөөллийн бүсэд гадаргын уст цэг байгаа тул нөлөөлөл үзүүлнэ, гүний усны түвшинд барилгын ажил явагдахгүй учраас нөлөөлөхгүй.
5	Хөрс, газрын гадарга	Их	Ажлын үед хөрс хуулалт, газар ухалтын ажил хийгдэх тул энд үзүүлэх нөлөөллийг их зэрэг гэж үзсэн.
6	Ургамал	Дунд	Ургамал бүхий талбай нийт трассын дагуу нөлөөлөлд өртөх тул энэ нөлөөллийн эрчим дунд байна.
7	Амьтан	Нөлөөлөлгүй	Барилгын талбай нь суурин газар учир хүн болон техникийн хөдөлгөөн, дуу чимээ ихтэй тул мэрэгч амьтад болон бор шувууны багийн жижиг шувууд болон синнантроп зүйлүүдээс бусад амьтад ерөнхийдөө дайжсан учир төслөөс амьтанд үзүүлэх шууд нөлөөлөл байхгүй.
8	Дуу чимээ, доргилт, чичиргээ	Бага	Барилга материал буулгах, ачих, тээвэрлэлт зэргээс үүсэх дуу чимээ, чичиргээ нь ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.
9	Үнэр	Бага	Ажилчдын кемпийн ахуйн хог хаягдлын цэгийг стандартын дагуу байгуулаагүй, ариун цэврийн байгууламж шаардлага хангахгүй зэргээс тухайн орчин нь үнэр үүсгэж болзошгүй тул барилгын ажлын эхний шатанд төлөвлөлтийг зөв хийх, үйл ажиллагааны турш нөлөөллийг бууруулах ажиллах боломжтой.

## **ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ**

Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний дагуу тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм.

2012 онд шинэчлэгдсэн Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБУ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар төсөл хэрэгжүүлэгч нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор БОМТ-г жил бүр шинэчлэн боловсруулж төрийн захиргааны байгууллагаар батлуулж хэрэгжүүлдэг (Заалт 9.1).

Уг төслийн зээл олгогч Азийн хөгжлийн банк (АХБ)-ны зүгээс тавих шаардлагын эн тэргүүнд байгаль орчинд халгүйгээр төслийг хэрэгжүүлэхийг шаарддаг бөгөөд энэ тал дээр өөрсдийн хамгааллын бодлоготой (Safeguard Policy Statement, 2009) ба ажлын талбар дээр БОМТ-ний хэрэгжилттэй байнга танилцаж, хяналт шалгалт явуулж байдаг тул байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээг сайтар төлөвлөж, цаг тухайд нь хэрэгжүүлж, үр дүнг тайлагнаж байх шаардлагатай байдаг.

### **ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улаан дэл услалтын системийн байгууламжийн барилгын ажлын үед нийгэм, эдийн засаг, нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг БОМТ-нд тусгасан болно. “Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ”-г төлөвлөхдөө ажлын үед байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээнүүдийг төлөвлөв.

Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь барилга, угсралтын ажлын явцад үүсэхээр байна. “Эдгээр нөлөө нь ажлын талбайн хэмжээнд хязгаарлагдахаас гадна түр хугацаатай бөгөөд хүрээлэн байгаа орчны эх үүсвэрт заналхийлэх, сулруулах хэмжээтэй биш” хэмээн дүгнэж байна.

**“Улаан дэл услалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**Хүснэгт 3. Сөрөг нөлөөлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арга хэмжээ**

№	Төслөөс үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
<b>Цаг уур, уур амьсгал</b>					
1	Тариалангийн талбай болон услалтын системийн барилга байгууламж гэнэтийн уруйн үерт өртөж эвдрэх, осол аваар гарах	Тус бүс нутагт эрчимшил ихтэй хур тунадаснаас үүдэлтэй гэнэтийн, уруйн шинжтэй үерүүд тохиолддог тул үерийн далан, суваг шуудууг хийж гүйцэтгэх	2023 оны 2-р улирлаас	Төслийн барилгын ажлын зардалд хамаарна.	Монгол Улсын барилгын норм ба дүрэм, “БНБД 33-01-03 Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам” Зам Тээвэр, Барилга, Хот Байгуулалтын Сайдын 2010 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 107 дугаар тушаал “Барилгын норм ба дүрэм батлах тухай /Усны барилга байгууламжийн бүүр/” Монгол Улсын барилгын норм ба дүрэм, “БНБД 33-09-10 Усжуулалтын систем, түүний байгууламж” 2010 он
2	Цаг уурын гэнэтийн, аюултай үзэгдлийн улмаас болзошгүй осол аваар гарах	Хэт халах, хүчтэй аадар бороо орох, хүчтэй салхилах, шороон шуурга шуурах, үер буух зэрэг байгаль цаг уурын аюултай үзэгдлийн үед барилга газар шорооны ажил болон материал тээвэрлэлтийн үйл ажиллагааг түр зогсоох, техник хэрэгслүүдийг унтрааж, ажиллагааг зогсоох	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он Машин механизмуудын аюулгүй ажиллагааны дүрэм
3	Барилгын цаг уурын мэдээ ашиглаагүй, тохиромжгүй үед барилга, газар шорооны ажлыг явуулснаас барилгын чанарын норм стандарт алдагдах, эвдрэл гэмтэл гарах	Услалтын системийн барилга, газар шорооны ажлыг барилгын цаг уурын мэдээнд үндэслэн гүйцэтгэх, цаг уурын мэдээтэй уялдуулан ажлын төлөвлөгөө гаргах	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	Монгол Улсын барилгын норм ба дүрэм, “БНБД 23-01-09 Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлтүүд” , 2009 он

**“Улаан дэл усалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Төслөөс үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
<b>Дүн (Цаг уур, уур амьсгал)</b>				-	
<b>Агаарын чанар</b>					
1	Материал тээвэрлэх болон бусад үйл ажиллагааны үед тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгөөнөөр агаарт тоосжилт үүсэх	Тоосжилт бууруулахын тулд усалгааны арга ашиглан шороон замаас үүсэх тоосжилтыг бууруулах	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
2	Материал тээвэрлэх болон бусад үйл ажиллагааны үед тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгөөнөөр агаарт тоосжилт үүсэх	Барилгын ажилд стандартын дагуу сайтар угааж шигшсэн элс, хайрга, дайрга ашиглах		Төслийн барилгын ажлын зардалд хамаарна.	Барилга байгууламжийн ажилд хэрэглэх элс, хайрга, дайргын стандарт MNS-392-98
3	Материал тээвэрлэх болон бусад үйл ажиллагааны үед тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгөөнөөр агаарт тоосжилт үүсэх	Шороон замаар зорчих тээврийн хэрэгслүүдийн хурдыг 30-40 км/цаг-аар хязгаарлах буюу энэ хурднаас хэтрүүлэхгүй байх зохицуулалт хийх		-	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
4	Материал тээвэрлэх болон бусад үйл ажиллагааны үед тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгөөнөөр агаарт тоосжилт үүсэх	Шороон замаар зорчих ачааны автомашинуудын хоорондын зайг 20 секундээс багагүй байхаар тогтоож, өмнөх машины үүсгэсэн тоос сарниж үзэгдэх орчин сайжрах боломжийг олгох, замын ачаалалд хяналт тавих	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016

**“Улаан дэл усалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Төслөөс үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
5		Шороон зам дагууд замын анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, санамж бүхий самбар байршуулж, барилгын ажилчид болон материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслүүдийг зөвхөн нэг замаар зорчих нөхцөлийг бүрдүүлэх, шинээр олон салаа шороон зам үүсгэхгүй байх арга хэмжээ авах	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	500.0	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
6	Усалтын системийн барилга газар шорооны ажлын үед ашиглах элс, хайрга, цемент зэрэг материалуудын овоолгоос салхины үйлчиллээр тоос босох	Полиэтилен болон даавуун хучлагаар барилгын материалын овоолгыг (элс, хайрга, цемент г.м) хучих	Салхины хурд ихтэй үед (2023 он)	500.0	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
7		Задгай талбайд овоолох барилгын материалыг газрын гадаргаар тархахаас сэргийлж хаалт, хашилт хийх	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
8	Материал тээвэрлэх үед ачааны хэсгээс тоос үүсэх, асгарах	Салхинд хийсч тоос үүсгэхгүйц материал тээвэрлэхдээ тээврийн хэрэгслийн ачааны хэсгийг битүүмжлэн хучих арга хэмжээ авах	Материал тээвэрлэх үед (2023 он)	-	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
9	Хүнд даацын машин механизмын дутуу шаталтат хөдөлгүүрээс хийн төлөвт бохирдуулагч ялгарч агаар бохирдуулах	Барилга, газар шорооны ажлын үед ашиглах хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжинд сайн чанарын түлш ашиглаж агаарт ялгарах хийн төлөвт бохирдуулагчийг багасгах	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	Барилгын ажил гүйцэтгэгч байгууллагын төлөвлөлтийн зардалд хамаарна.	“Бензин хөдөлгүүртэй автомашин– утааны найрлага дах хорт бодисын ЗДХ ба хэмжих арга” MNS 5013:2009 “Дизель хөдөлгүүртэй автомашин– утааны тортогжилтын ЗДХ ба хэмжих арга” MNS 5014:2009

**“Улаан дэл усалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Төслөөс үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
10		Нийт машин механизмуудыг үзлэг оношилгоонд хамруулж, шаардлагатай бол хөдөлгүүрийг шинэчилж сайжруулах, хорт утаа ихээр ялгаруулж буй машин техникийг барилгын ажилд ашиглахгүй байх, шаардлагатай үед хаягдал утааг шүүх шүүлтүүр, катализатор хэрэглэх	Барилгын ажил эхлэхээс өмнө (2023 он)	Барилгын ажил гүйцэтгэгч байгууллагын төлөвлөлтийн зардалд хамаарна.	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885 : 2008
11	Бензин, шатах тослох материалын хадгалалтын горим алдагдсанаас агаар бохирдуулах	Бензин, шатах тослох материалыг асгарч, ууршихааргүй байдлаар сайтар таглаж битүүмжлэн нарны шууд тусгал, галын эх үүсвэрээс тусгаарлан хадгалах, шатах тослох материалаар агаар бохирдох, шаталт үүсгэж агаарт хорт хий ялгаруулахаас сэргийлэх	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
12	Материал тээвэрлэлт, буулгалтын үед асгарсан элс, шороо, шавраас тоос босч агаар бохирдуулах	Барилгын талбайн хамгаалалтын зурвасаас гадна нийтийн эзэмшлийн зам дээр шаварлаг ба тоос ихтэй материал асгасан бол усаар шүршин чийгшүүлсний дараа хүрэээр хусаж авах, шүүрдэх зэргээр цэвэрлэнэ.	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
<b>Дүн (Агаарын чанар)</b>				<b>1000.0</b>	
<b>Газрын гадарга, хөрсөн бүрхэвч</b>					

**“Улаан дэл усалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Төслөөс үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
1	Хөрсний үржил шим алдагдах, эвдрэл үүсэх	Нөлөөлөлд өртөөгүй эрүүл талбайг хөндөж хөрс хуулах бол өнгөн хөрсийг тусгай талбайд хадгалж, барилгын ажил дууссаны дараа эвдэрсэн талбайг нөхөн сэргээхдээ ашиглах, аль болох богино хугацаанд олон наст ургамлын үр тарих замаар хөрсийг нөхөн сэргээж элэгдлээс хамгаалах	Барилга, газар шорооны ажлын үед (2023 он)	Зардлыг нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгав.	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012 он Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916 : 2008
2	Хөрсний үржил шим алдагдах, эвдрэл үүсэх, хатуу хог хаягдлаар бохирдох	Барилгын ажлын үед нэг цэгээс дараагийн цэг рүү шилжих шилжилт тутамд засвар дууссан газрын нөлөөлөлд өртсөн гадаргыг нөхөн сэргээж ухаш, овоолго үлдээхгүй байх, хатуу хог хаягдлыг тогтмол түүж цэвэрлэх	Барилгын ажлын үед (2023 он)	-	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012 он Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916 : 2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918 : 2008 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 : 2019
3	Газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн өнгөн хэсэг элэгдэх, ургамлан нөмрөг устгах	Барилгын материалуудыг аль болох нэг цэгт төвлөрүүлэх	Барилгын ажлын үед (2023 он)	-	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012 он Байгаль орчин. Газар. Газар ашиглалт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 3473:1983
4	Газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн өнгөн хэсэг элэгдэх, ургамлан нөмрөг устгах	Ажлын үед овоолсон шороо болон бусад хэт налуу орчинг багасгах	Барилгын ажлын үед (2023 он)	-	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012 он Байгаль орчин. Газар. Газар ашиглалт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 3473:1983
5	Газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн өнгөн хэсэг элэгдэх, ургамлан нөмрөг устгах	Экскаватороор үхсэн нүхийг ил орхигоос сэргийлэх, усалгааны хоолой суулгах шуудуу гаргахад нягтруулдаг техник ашиглах	Барилгын ажлын үед (2023 он)	-	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012 он Байгаль орчин. Газар. Газар ашиглалт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 3473:1983



**“Улаан дэл усалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Төслөөс үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
6	Барилгын материалын болон ахуйн хаягдлаар орчныг бохирдуулах	Барилгын материалын хаягдлыг богино хугацаанд төслийн талбайгаас зайлуулах, хог хаягдлыг нэг цэгт төвлөрүүлэх, үүссэн хаягдлыг хийсч тархахааргүй битүүмжлэл сайтай цэгт түр хадгалах арга хэмжээ авах	Барилгын ажлын үед (2023 он)	Зардлыг хог хаягдлын төлөвлөгөөний хэсэгт тусгав.	Хог хаягдлын тухай хууль, 2017 он Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344 : 2011
7	Хөрсийг нефтийн бүтээгдэхүүн, хүнд металаар бохирдуулж болзошгүй.	Бензин, шатах тослох материалыг асгарч, ууршихааргүй байдлаар сайтар таглаж битүүмжлэн нарны шууд тусгал, галын эх үүсвэрээс тусгаарлан хадгалах, шатах тослох материалаар хөрс бохирдохоос сэргийлэх	Барилгын ажлын үед (2023 он)	-	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 : 2019
8	Бүх төрлийн шатах, тослох материалаар ажилладаг машин механизм, тээврийн	Шатах тослох материалаар бохирдсон хөрсийг нэн даруй хусаж аван хөрсний гүн рүү нэвчихээс сэргийлэх	Барилгын ажлын үед (2023 он)	-	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 : 2019
9	хэрэгслүүдийн ашиглалтын үед шатах тослох материал асгарч хөрс бохирдуулах	Шатах тослох материал их хэмжээгээр асгарсан бол элс, даавуу зэрэг шингээгч материалд шингээн авч битүү саванд хийх, асгарсан хэсгийн хөрсийг хуулж авах	Барилгын ажлын үед (2023 он)	-	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 : 2019
10	Хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол үүсэх	Барилга, газар шорооны ажил бүрэн дууссаны дараа нөлөөлөлд өртсөн нийт талбайг нөхөн сэргээж, хуучин төрх байдалд нь оруулах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг барилгын ажил дууссанаас хойш 10-15 хоногт багтаан бүрэн хийж дуусгах	Барилгын ажлын дараа (2023 он)	Зардлыг нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэсэгт тусгав.	Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918 : 2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 5914 : 2008 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2020
<b>Дүн (Газрын гадарга, хөрсөн бүрхэвч)</b>				-	

**“Улаан дэл усалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Төслөөс үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
<b>Гадаргын болон газрын доорх ус</b>					
1		Барилгын ажлын үед голын байгалийн үндсэн голдирол, урсцыг өөрчлөх үйл ажиллагаа явуулахгүй байх	Барилгын ажил	-	Усны тухай хууль, 2012 он Монгол Улсын байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн А-230/127 дугаар хамтарсан тушаал, “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”
2	Гадаргын усны урсац, горим өөрчлөгдөх	Барилгын ажлын үед усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсэд (голын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд) хамаарах газраас элс, хайрга чулуу авч ашиглахгүй байх	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	
3	Ус, салхины нөлөөгөөр эрэг нурах	Ус авах байгууламж болон гол сүвгийн дагуух эрэгт чулуун хашлага хийж эргийн нуралт үүсгэхээс хамгаалах;	Барилгын ажлын үед (2023 он)	Барилгын ажлын зардалд хамаарна.	
4	Гадаргын ус хатуу, шингэн хаягдлаар бохирдох	Голын усанд машин угаах, голын ойр орчимд бие засах, хог хаягдал ил задгай хаяхгүй байх талаар барилгын ажилчдад хатуу анхааруулах ба үүнд талбайн инженер хатуу хяналт тавьж ажиллах	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	
5	Гадаргын болон газрын доорх ус ахуйн шингэн хаягдлаар бохирдох	Ахуйн шингэн хаягдлыг ил задгай асгахгүй байх	Барилгын ажил эхлэхээс өмнө	Зардлыг хог хаягдлын төлөвлөгөөний хэсэгт тусгав.	
6	Гадаргын болон газрын доорх ус хатуу, шингэн хаягдлаар бохирдох	Хатуу хаягдлын түр цэгүүдийг стандартын шаардлагад нийцүүлэн сайтар битүүмжлэн байгуулах ба хаягдлыг богино хугацаанд төвлөрсөн цэг рүү зөөвөрлөх, хатуу хог хаягдал гол руу хийсч орохоос сэргийлэх	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед	Зардлыг хог хаягдлын төлөвлөгөөний хэсэгт тусгав.	

**“Улаан дэл усалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Төслөөс үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
7	Барилгын ажлын үед илүүдэл хаягдал усаар гадаргын усыг бохирдуулах	Барилгын талбайн гадаргын урсац голын ус руу орохоос сэргийлэн хамгаалалтын суваг байгуулах	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	Барилгын ажлын зардалд хамаарна.	Усны тухай хууль, 2012 он Монгол Улсын байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн А-230/127 дугаар хамтарсан тушаал, “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”
8	Усан орчныг бохирдуулах	Бүх машин механизм, ажилчдын голын суваг руу орох, гарах гарцыг хатуу зааглаж тогтооно. Энэ нь суваг болон амьдрах орчны ойролцоох хэсгүүдэд үзүүлэх нөлөөллийг багасгана.	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	
9	Усан орчныг бохирдуулах	Бохирдуулагч бодисууд суваг руу орох эрсдэлийг багасгахын тулд суваг руу орох бүх машин механизмыг нэвтрэхээс өмнө цэвэрлэж, бохир алдагдаж асарч буй эсэхийг шалгана.	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	
10	Тээврийн хэрэгсэл, машин механизмын бүрэн бүтэн байдал алдагдаж, тос масло гоожих, улмаар гадаргын болон газрын доорх ус бохирдуулах	Машин техникийн аюулгүй ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хангах, шаардлагатай үед засвар үйлчилгээг зориулалтын засварын газарт хийлгэх	Барилгын ажлын үед (2023 он)	Барилгын ажил гүйцэтгэгч байгууллагын төлөвлөлтийн зардалд хамаарна.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он
11	Усалтын системийн барилга байгууламжуудын битүүмжлэл муу байснаас ашиглалтын	Усалтын системийн барилга байгууламжууд буюу усан сан, гол суваг, далд сувгийн битүүмжлэлийг стандартын дагуу хийж, шүүрэлт үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх	Барилгын ажлын үед (2023 он)	Төслийн барилгын ажлын зардалд хамаарна.	Усны тухай хууль, 2012 он Монгол Улсын барилгын норм ба дүрэм, “БНБД 33-09-10 Усжуулалтын систем, түүний байгууламж” 2010 он

**“Улаан дэл усалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Төслөөс үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
12	үед шүүрэлт үүсч, усны алдагдал ихсэх, ус хэрэглээ тооцоот хэрэглээнээс давах	Шүүрэлт үүсгэхгүй байхын тулд гол сувгийг бетоноор доторлох, усан санд пелёнк дэвсэх, гол сувгийн эргийн нуралтаас сэргийлэхийн тулд чулуун өрлөг хийх	Барилгын ажлын үед (2023 он)	Төслийн барилгын ажлын зардалд хамаарна.	Хүрээлэн байгаа орчин. Усны нөөц, ус ашиглалт, хамгаалалт. Нэр томъёо, тодорхойлолт MNS 6694 : 2017
13	Усалтын системийн ашиглалтын үед химийн бордоо, пестицидийн хэрэглээ, хадгалалтын нөхцөлөөс хамаарч хөрсний усаар дамжин гадаргын болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй	Төслийн талбайд байгаа 50м гүн мониторингийн цооногт газрын доорх усны бохирдол, усны түвшнийг тогтмол хэмжиж, усны чанарын стандарттай харьцуулан тэмдэглэл хөтлөх, тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлаңд мониторингийн цооногийн шинжилгээний үр дүнг тусгах;	Улирал бүр	ОХШХ-н зардалд хамаарна.	Усны тухай хууль, 2012 он Усны чанар. Гүний усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх агууламж, MNS 6148:2010 Гүний усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлагууд. MNS 3342:1982
<b>Дүн (Гадаргын болон газрын доорх ус)</b>				-	
<b>Ургамлан нөмрөг</b>					
1	Барилгын ажлын нөлөөгөөр байгалийн ургамлан нөмрөг устгах, доройтох	Барилгын ажлын төлөвлөлт, газар ашиглалтыг зөв хийж ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлэх талбайг хамгийн бага хэмжээнд байлгах	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	Байгалийн ургамлын тухай хууль, 1995 он Ургамал хамгааллын тухай хууль, 2007 он Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 08 дугаар сарын 25 – ны өдрийн 153 дугаар тогтоол, Ховор ургамлын жагсаалт
2	Барилгын ажлын нөлөөгөөр байгалийн ургамлан нөмрөг устгах, доройтох	Барилгажих талбайд ховор, нэн ховор статустай, эмийн ач холбогдол бүхий хамгаалах шаардлагатай ургамал байвал шилжүүлэн суулгах арга хэмжээ авах, нэн ховор, ховор, эмийн ашигт ургамлуудыг түүж бэлтгэхгүй байх	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	Байгалийн ургамлын тухай хууль, 1995 он Ургамал хамгааллын тухай хууль, 2007 он Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 08 дугаар сарын 25 – ны өдрийн 153 дугаар тогтоол, Ховор ургамлын жагсаалт

**“Улаан дэл усалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Төслөөс үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
3	Барилгын ажлын нөлөөгөөр байгалийн ургамлан нөмрөг устгах, доройтох	Барилгын материал, машин механизмуудыг ургамлан нөмрөг бага буюу аль холбох халцгай газарт байрлуулах, байгалийн ургамалтай газарт барилгын материал буулгах, машин механизмын зогсоол болгон ашиглахгүй байх	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	Байгалийн ургамлын тухай хууль, 1995 он Ургамал хамгааллын тухай хууль, 2007 он Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 08 дугаар сарын 25 – ны өдрийн 153 дугаар тогтоол, Ховор ургамлын жагсаалт
<b>Дүн (Ургамлан нөмрөг)</b>				-	
<b>Амьтны аймаг</b>					
1	Зэрлэг амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөнд саад учруулах	Хэрэв барилгын ажлын явцад зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнтэй таарвал үргээлгүй зам тавьж өгөн өнгөрөөж байх;	Барилгын ажлын үед (2023 он)	-	Амьтны тухай хууль, 2012 он Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 01 дүгээр сарын 11- ний өдрийн 7 дугаар тогтоол, Ховор амьтны жагсаалт
2	Нүүдлийн шувуудыг үргээх, амьдарлын хэв маягийг нь өөрчлөх, тааламжгүй нөхцөлийг бүрдүүлэх	Нүүдлийн шувууд дайран өнгөрдөг хугацаанд шувуудыг үргээдэг хүчин зүйлүүдэд хяналт тавьж, ажилчдад мэдээлэл өгч шувуудыг аль болохоор үргээж цочоохгүй байх	Барилгын ажлын үед (2023 он)	-	-
3	Аюулд орсон амьтдад шуурхай тусламж үзүүлж чадаагүй бол тоо толгой нь хорогдох	Бэртэж гэмтсэн, аюулд орсон зэрлэг ан амьтантай таарвал орон нутгийн байгаль хамгаалагчид мэдэгдэж шуурхай арга хэмжээ авах	Барилгын ажлын үед (2023 он)	-	Амьтны тухай хууль, 2012 он Ан агнуурын тухай хууль, 2000 он Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 01 дүгээр сарын 11- ний өдрийн 7 дугаар тогтоол, Ховор амьтны жагсаалт
4	Хууль бус ан агнуурын үйл ажиллагаа явагдах	Барилгын ажилчдад хууль бус ан агнуур хийхгүй байх, худалдаалахгүй байх талаар анхааруулга өгч, хяналт тавьж ажиллах	Барилгын ажлын үед (2023 он)	-	
5	Далангийн хаалтыг хаалттай байлгаснаас	Суваг шуудуу, толгойн барилгын хаалт зэргийг загас өнгөрүүлэх боломжтой байхаар төлөвлөн байгуулах	Барилгын ажлын үед (2023 он)	Төслийн барилгын ажлын зардалд хамаарна.	Монгол Улсын барилгын норм ба дүрэм, “БНБД 33-09-10 Усжуулалтын систем, түүний байгууламж” 2010 он

**“Улаан дэл услалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Төслөөс үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
	загас дамжин өнгөрөх боломжгүй болох				
6	Усан орчинд амьдарч буй амьтдын амьдрах орчныг өөрчлөх,	Гол суваг, усан санд загас орвол амьдрах орчны хувьд тохиромжгүй тул голоос ус авах толгойн барилгад загас орохоос сэргийлсэн тор тавьж гол сувагт загас орохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх	Барилгын ажлын үед (2023 он)		Монгол Улсын барилгын норм ба дүрэм, “БНБД 33-09-10 Усжуулалтын систем, түүний байгууламж” 2010 он
<b>Дүн (Амьтны аймаг)</b>				-	
<b>Нийгэм, хүний эрүүл мэнд</b>					
1	Орон нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах	Услалтын системийн барилга, газар шорооны ажлыг зөвхөн өдрийн цагаар явуулах буюу 18:00 цагаас хойш чанга дуу чимээ гаргахгүй байх		-	
2	Орон нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах,	Хэт их чимээтэй үйл ажиллагааг зэрэг явуулах, чанга дуутай тоног төхөөрөмжүүдийг нэг байршилд нэгэн зэрэг ажиллуулахаас аль болох зайлсхийж барилгын ажлыг төлөвлөх	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	Барилгын тухай хууль, 2016 он Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы ертөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага MNS 6768 : 2019 Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Хөдөлмөр хамгааллын хэмжилзүйн хангалт MNS 12-0-006 : 1989 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990 : 2015
3	ажилчдын эрүүл мэндэд хохирол учруулах	Барилгын ажлын үед аль болох дуу чимээ багатай машин механизмыг сонгож ашиглах, дуу чимээ ихээр гаргадаг машин, механизмыг дуу намсгагчаар тоноглож чимээ шуугианыг аль болгох бага гаргах		-	
4	Ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл бий болгох	Дуу чимээ ихтэй нөхцөлд ажиллаж буй ажилчдыг дуу чимээг багасгаж сонсголын эрхтэн системийг хамгаалах хэрэгслээр хангаж хэрэглүүлж хэвшүүлэх		Барилгын ажил гүйцэтгэгч байгууллагын	

**“Улаан дэл усалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Төслөөс үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
				төлөвлөлтийн зардалд хамаарна.	
5	Орон нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах, нөлөөлөлд өртөмтгий иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Барилгын материал тээвэрлэж буй машин сургууль, эмнэлэг, суурьшлын бүс зэрэг чимээнд мэдрэг газруудаар дайрч өнгөрөх, эдгээр газрын ойр орчимд явахдаа хурдаа хасах, дуут дохио ашиглахгүй байх		-	-
6	Орон нутгийн иргэдэд тодорхой мэдээлэл өгөөгүйн улмаас үл ойлголцол үүсэх	Барилгын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэх хугацаа, хийгдэх ажлуудын талаар иргэдэд мэдээлэл өгөхүйц мэдээллийн самбарыг барилгын талбайн орчимд байршуулах		300.0	Барилгын тухай хууль, 2016 он
7	Хүрээлэн буй орчинд тоос ихээр үүсгэх, дуу шуугианы түвшин нэмэгдэх нь иргэдийн тайван байдлыг алдагдуулах, урт хугацаанд үргэлжилснээр амьсгалын замын эрхтэн тогтолцоо гэмтэх, сонсголын эрхтэн гэмтэх, харшилтай болох гэх мэтээр нөлөөлөлд өртөж болзошгүй.	Барилгын ажлыг аль болох орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байхаар төлөвлөж, тоосжилт, дуу чимээг багасгах, бууруулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх		-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он
8	Хүрээлэн буй орчинд тоос ихээр үүсгэх, дуу шуугианы түвшин нэмэгдэх нь иргэдийн тайван байдлыг алдагдуулах, урт хугацаанд үргэлжилснээр амьсгалын замын эрхтэн тогтолцоо гэмтэх, сонсголын эрхтэн гэмтэх, харшилтай болох гэх мэтээр нөлөөлөлд өртөж болзошгүй.	Дуу чимээ ихтэй машин механизмүүдийг ашиглаагүй үедээ байнга унтрааж хэвшүүлэх	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он
9	Хүрээлэн буй орчинд тоос ихээр үүсгэх, дуу шуугианы түвшин нэмэгдэх нь иргэдийн тайван байдлыг алдагдуулах, урт хугацаанд үргэлжилснээр амьсгалын замын эрхтэн тогтолцоо гэмтэх, сонсголын эрхтэн гэмтэх, харшилтай болох гэх мэтээр нөлөөлөлд өртөж болзошгүй.	Барилгын ажлын явцад орон нутгийн иргэдээс ирсэн аливаа санал гомдлыг хүлээн авч богино хугацаанд шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд нэгдсэн журмаар мэдээлэл өгөх		-	-

**“Улаан дэл усалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Төслөөс үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
10	ХАБЭА-н дүрэм зөрчигдөх, осол аваар гарах	Барилгын ажилчдад ажил эхлэхээс өмнө ХАБЭА-н зааварчилгаа өгч, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжөөр бүрэн хангах, хэрэглүүлж хэвшүүлэх	Барилгын ажлын үед өдөр бүр (2023 он)	Барилгын ажил гүйцэтгэгч байгууллагын төлөвлөлтийн зардалд хамаарна.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он Тусгай зориулалтын ажлын хувцас. Ерөнхий шаардлага MNS 6231 : 2011 Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага, ангилал MNS 4931 : 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Хамгаалалтын хувцас - Ерөнхий шаардлага MNS ISO 13688 : 2000
11		Машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байх, эвдэрч доголдсон тоног төхөөрөмжийн ашиглалтыг нэн даруй зогсоох			Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 4968 : 2000
12	Анхны тусламж үзүүлэх эм тариа, багаж хэрэгсэл байхгүйн улмаас ослын нөхцөлийг хүндрүүлэх	Ажилчдад аливаа болзошгүй аваар ослын үед анхны тусламж үзүүлэх сургалт зааварчилгааг өгч, анхны тусламжийн эм тариа, багаж хэрэгслийг бэлэн байлгах		500.0	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он
<b>Дүн (Нийгэм, хүний эрүүл мэнд)</b>					<b>800.0</b>
<b>НИЙТ ДҮН</b>					<b>1800.0</b>



**ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн төслийн талбайн нутаг дэвсгэртээ иргэдийн хуулиар баталгаажсан эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, байгаль орчин, ногоон хөгжлийн суурь үзэл санааг хэрэгжүүлэн хүн аюулгүй, эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлж, үйл ажиллагаа дууссаны дараа тухайн орчинд экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан, хүн, мал амьтан болон биологийн төрөл зүйл амьдрахад аюулгүй амьдрах орчныг бий болгоход нөхөн сэргээлтийн гол зорилго оршино. Байгалийн нөөц баялгийг тогтвортой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэхэд оршино. Үүнд:

- ✓ Хойч үедээ экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан
- ✓ Бохирдуулагч төлөх ёстой зарчмыг баримтлах
- ✓ Биологийн төрөл зүйлийг хамгаалах
- ✓ Экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцан хамаарал, холбоо, тэнцвэрт байдлыг хадгалах

Улаан дэл услалтын системийн барилгын ажлын дараа нөхөн сэргээлтийн үе шатанд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд

**Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө**

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
1	Биологийн нөхөн сэргээлт нөхцөлийг бүрдүүлэх хийх	Барилга, газар шорооны ажил дууссаны дараа эвдрэлд орсон талбайг хэлбэршүүлэх, тэгшлэх, үржил шимт хөрсөөр хүчих, шаардлагатай тохиолдолд хөрс сайжруулалт хийх зэргээр ургамалжуулах урьдач нөхцөлийг бүрдүүлэх	Барилгын ажлын дараа 10-15 хоногт багтаан бүх нөхөн сэргээлтийн ажлыг дуусгах	-	Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916 : 2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS 5914:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага” MNS 5918:2008
2	Биологийн нөхөн сэргээлт эвдэрсэн газрыг байгалийн нөхөн сэргээх хийж унаган	Тэгшилж зассан газарт олон наст ургамлын үр цацах, мод, сөөг тарих зэргээр нөхөн сэргээх		-	Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2011

**“Улаан дэл услалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
	төрхөнд нь эргүүлэн оруулах				
3	Гадаргын усны ууршилтыг багасгах, хөрс хамгаалах, нөхөн сэргээх	Услалтын системийн талбайг тойруулан 1500 мод тарьж, ойн зурвас байгуулах	Барилгын ажлын үед	25000.0	Мод, сөөгний үрийг тарихад бэлтгэх. Ерөнхий шаардлага MNS 6253-1 : 2011 Мод, сөөгний үр тарих. Ерөнхий шаардлага MNS 6253-2 : 2011 Мод, сөөгний үр тарьсны дараа арчлах. Ерөнхий шаардлага MNS 6253-3 : 2011 Мод, сөөгний суулгац арчлах MNS 6258-2 : 2011 Мод үржүүлгийн газар бордоо хэрэглэх MNS 6252 : 2011
4		Ойн зурвасыг мэргэжлийн байгууллагын заавар зөвлөмжийн дагуу байгуулах ба орон нутгийн уур амьсгалд тохирсон хайлаас, жигд, улиас, сүхай, харгана зэрэг говь цөлийн бүсэд тарихад тохиромжтой мод бутыг тарьж, усалгаа, арчилгааг тогтмол хийх, арчилгааг тусгай, мэргэжлийн ажилтнуудад хариуцуулах	Тогтмол	-	
<b>НИЙТ ДҮН</b>				<b>25,000.0</b>	

**ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төсөл хэрэгжүүлэгч аливаа аж ахуйн нэгж, байгууллага МУ-ын Соёлын өвийн тухай хуульд заасны дагуу түүх, соёлын өвийг авран хамгаалах үүрэгтэй байдаг.

“Соёлын өвийг хамгаалах тухай” Монгол улсын хуулийн 6 дугаар бүлгийн 17 дугаар зүйлд “газрын хэвлийг ашиглах явцад түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ашиглагч нь ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ” Хэрэв энэхүү заалтыг зөрчсөн тохиолдолд 200.000-250.000 төгрөгөөр торгож, үйл ажиллагаа, судалгаа шинжилгээ хийх, хувиан олшруулах, хуулбар хийх, хадгалалтыг зогсоох, хууль бусаар олсон орлогыг хураах арга хэмжээ авахаар заажээ.

**Хүснэгт 5. Соёлын өвийг хамгаалах арга хэмжээ**

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Түүх, соёлын дурсгалт зүйл	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл барилгын ажлаа зогсоож энэ тухай, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх	Төслийн хүрээнд	-	Тухайн үед нь шийдэх	Барилгын ажлын үед, дэд бүтцийн бүтээн байгуулалтын үед буюу тухай бүрд нь	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

**НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх зардал**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол	Урьдчилан сэргийлэх мэдээ болон дохиолол холбооны найдвартай байдлуудыг байнга хангах	Төслийн бүх байршилд		-		Барилгын бүхий л үйл ажиллагааны туршид	
2.	Хөдөлмөрийн сахилга бат алдсанаас үүсэх осол	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, дотоод хяналт, байгууллагын дотоод дүрэм журам мөрдөж, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх			-			Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
3.	Хүний буруутай үйл ажиллагаагаар байгаль орчин бохирдох	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг 1 удаа зохион байгуулах, сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах			-			Байгаль хамгаалах тухай хууль
4.	Гал түймрийн болзошгүй аюул	Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах			250.0			Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 3 дугаар бүлэг Гамшгаас хамгаалах тухай хууль, 5 дугаар бүлэг

**“Улаан дэл услалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
5.	Цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй байдал алдагдаж, эрсдэл гарах	Цахилгаан төхөөрөмжийн цахилгаан тоног хүчдэл, хангамж, газардуулгад үзлэг хийж гэмтлийг залруулах		-	-	-		
6.	Барилгын талбайд болзошгүй осол аваарын нөхцөл байдал үүсэх	Барилгын ажлын талбайд гэрэлтүүлэг, анхааруулах самбар, тэмдэг, тэмдэглэгээ, дохио үг зэргийг зохих байршлуудад хийх			1,000.0			
<b>Осол, эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх нийт, мян.төг</b>						<b>1,250.0</b>		

## ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө нь “Улаан дэл услалтын систем”-ийн барилгын ажлын явцад гарч болох хог хаягдлын эх үүсвэрийг Монгол улс болон олон улсын хууль тогтоомж, стандарт шаардлагын дагуу хянах, бууруулахад чиглэгдэх юм.

Аливаа үйлдвэрлэл, төслийн үйл ажиллагаанаас үүдэн хог хаягдал үүсгэх нь зайлшгүй бөгөөд холбогдох хууль, журмын дагуу хог хаягдлын менежментийг системийн арга хандлагыг тодорхойлсон болно.

Төлөвлөгөөнд төслийн холбогдох стандартуудыг тогтоох, нөлөөлөл бууруулах арга хэмжээний хяналт шинжилгээ ба аудитын хөтөлбөр зэрэг төслийн хог хаягдлын менежментийн удирдлагуудыг тогтоож өгсөн.

### 9.1. ЗОРИЛГО

Энэхүү менежментийн төлөвлөгөөний зорилгууд нь:

- Хог хаягдлын менежментийн талаарх дотоодын болон олон улсын хууль, журам, стандартуудыг тодорхойлох;
- Барилгын ажлын үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын нөлөөллийн болзошгүй эх үүсвэрүүдийг тодорхойлох;
- Хог хаягдлын менежментийн үйл ажиллагааны журмуудыг тодорхойлох;
- Үүрэг, хариуцлагуудыг тодорхойлох;
- Хяналт шинжилгээ/аудит болон тайлагнах журмуудыг тодорхойлох;
- Ажилчдад зориулсан сургалт зэрэг багтана.

### 9.2. ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧИН

Хог хаягдлыг цуглуулах, ялгах, хадгалах, боловсруулах, зайлуулахтай холбоотой Монгол улсын болон олон улсын дүрэм журам, стандартуудыг заасан болно.

#### 9.2.1. Монгол улсын хууль

##### “Хог хаягдлын тухай хууль” 2017 он

##### **1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

Энэ хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн зүйл, заалтууд

- 10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийтлэг эрх, үүрэг
- 10.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах эрх эдэлнэ:
- 10.1.1. хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх, хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах;
- 10.1.2. хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах.
- 10.2. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэг хүлээнэ:
- 10.2.1. энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах;
- 10.2.2. энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хогийн савтай байх;
- 10.2.3. аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;
- 10.2.4. хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх;
- 10.2.5. үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх;
- 10.2.6. нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох;
- 10.2.7. хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх;
- 10.2.8. хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх;
- 10.2.9. эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх;
- 10.2.10. энэ хуулийн 9.4.12-т заасан нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх;
- 10.2.11. барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах;
- 10.2.12. хог хаягдлын талаархи сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх;
- 10.2.13. хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах;
- 10.2.14. хог хаягдлын талаархи хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах;
- 10.2.15. хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх;
- 10.2.16. аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;
- 10.2.17. үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх;
- 10.2.18. аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авах, аюулгүй ажиллагааг хангах.
- 10.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараахь үйл ажиллагааг хориглоно:
- 10.3.1. хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях;
- 10.3.2. нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях;
- 10.3.3. хог хаягдлыг ил задгай шатаах;

- 10.3.4.гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах;
- 10.3.5.хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях;
- 10.3.6.аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах;
- 10.3.7.нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх.
- 14 дүгээр зүйл. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх
- 14.1.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлж, дугаар авсан байна.
- 14.2.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ.
- 14.3.Энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн үйл ажиллагааг эрхлэхийг хориглоно.
- 14.4.Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоож, сум, дүүргийн Засаг даргаар батлуулж мөрдөнө.
- 14.5.Энэ хуулийн 14.4-т заасан хуваарийн дагуу хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагад хүлээлгэж өгнө.
- 14.6.Энгийн хог хаягдлыг зориулалтын, битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.
- 14.7.Энгийн хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нь зохих сургалтад хамрагдаж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.
- 14.8.Энэ хуулийн 14.2-т заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үед түүнийг унах, асгарах, хийсэхээс сэргийлэх арга хэмжээ авна.
- 40 дүгээр зүйл. Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах
- 40.1.Хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах замаар эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэнэ.
- 40.2.Үйлдвэрлэгч нь бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ дахивар нөөц сонгож, хаягдалгүй болон хамгийн бага хог хаягдал гаргах технологи ашиглана.
- 40.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь дахин боловсруулсан, сэргээн ашигласан бүтээгдэхүүн худалдан авах замаар ногоон худалдан авалтыг дэмжинэ.
- 40.4.Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид эдийн засгийн урамшуулал олгоно.
- 40.5.Энэ хуулийн 8.1.14-т заасан жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, экспортлох үүрэгтэй.
- 40.6.Үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг цуглуулж, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах, устгах, экспортлох амьдралын мөчлөгийг харуулсан схемтэй байх ба түүнийг олон нийтэд нээлттэй байлгана.
- 40.7.Хог хаягдлыг дахин боловсруулж хийсэн бүтээгдэхүүн болон дахин боловсруулагдах хог хаягдал үүсгэх бүтээгдэхүүн нь энэ хуулийн 8.1.13-т заасан таних тэмдэгтэй байна.
- 40.8.Хог хаягдлыг ангилах, цуглуулах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах байгууламж болон хог хаягдлын төвлөрсөн цэг, үйлдвэр технологийн паркийн газрыг эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг Газрын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 41 дүгээр зүйл.Хог хаягдлын үйлчилгээний хураамж



- 41.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлын үйлчилгээний хураамж төлнө.
- 41.8.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлнэ.
- 41.12.Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх болон хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих, бүх нийтийн их цэвэрлэгээ, сургалт, сурталчилгаа зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулагдах зардлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт тусгаж зарцуулна
- 43 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага
- 43.1.Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч, цагдаа болон сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга дараахь хариуцлага хүлээлгэнэ:
- 43.1.1.энэ хуулийн 7.1.2-тзаасан журмыг зөрчсөн бол хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгох;
- 43.1.2.энэ хуулийн 8.2.1, 8.3.2, 8.5.1, 8.6.2, 9.1.3-т заасан журмыг зөрчсөн бол хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;
- 43.1.3.энэ хуулийн 10.2.1, 10.2.4, 10.2.5, 10.2.7, 10.2.9, 10.2.10, 10.2.11-д заасныг зөрчсөн бол хүнийг гучин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;
- 43.1.4.энэ хуулийн 10.3.1, 10.3.2-тзаасныг зөрчсөн бол хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;
- 43.1.5.энэ хуулийн 10.3.3, 10.3.4-тзаасныг зөрчсөн хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун мянган төгрөгөөр торгох;
- 43.1.6.энэ хуулийн 10.3.5-д заасныг зөрчсөн хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;
- 43.1.7.энэ хуулийн 10.3.6-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг хоёр зуун мянган төгрөгөөр торгох;
- 43.1.8.энэ хуулийн 10.3.7-д заасныг зөрчсөн хүнийг тавин мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох;
- 43.1.9.энэ хуулийн 14.4, 14.5, 14.6, 14.8-д заасныг зөрчсөн хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох;
- 43.1.10.энэ хуулийн 14.3-тзаасныг зөрчсөн хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн зуун мянган төгрөгөөр торгох;
- 43.1.11.энэ хуулийн 16.8-д заасныг зөрчсөн хүнийг таван зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;
- 43.1.12.энэ хуулийн 18.1-д заасныг зөрчсөн хүнийг таван зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгох;
- 43.1.13.энэ хуулийн 20.1, 20.2-т заасныг зөрчсөн хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун мянган төгрөгөөр торгох;
- 43.1.14.энэ хуулийн 20.4-т заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;
- 43.1.15.энэ хуулийн 24.1-д заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгох;
- 43.1.16.энэ хуулийн 25.1-д заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр саятөгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;
- 43.1.17.энэ хуулийн 26.1-д заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;
- 43.1.18.энэ хуулийн 28.1-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөр торгож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

### “Улаан дэл услалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

43.1.19.нийтийн эдэлбэр газар болон ногоон бүсэд хог хаягдал хаясан иргэн, аж ахуйн нэгжийн зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг хурааж, зөрчил гаргасан хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван сая төгрөгөөр торгох;

43.1.20.энэ хуулийн 40.5-д заасныг зөрчсөн хүнийг нэг сая төгрөгөөр, хуулийн этгээдийг таван сая төгрөгөөр торгох;

43.1.21.энэ хуулийн 40.6-д заасныг зөрчсөн хүнийг нэг зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөр торгох;

43.1.22.энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх.

#### 9.2.2. Засгийн газрын тогтоол, сайдын тушаалаас

№	Нэр	Батлагдсан огноо, актын дугаар
Монгол улсын засгийн газрын тогтоол		
1	Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох талаар авах зарим арга хэмжээний тухай	2001 оны 256 дугаар тогтоол
2	Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг сурталчилж, урамшуулал олгох журам	2015 оны 06 сарын 29-ний өдөр батлагдсан 263 дугаар тогтоолын хавсралт
3	Хог хаягдлын норматив тогтоох аргачлал	Засгийн газрын 2015 оны 288 дугаар тогтоолын хавсралт
Сайдын тушаал		
1	Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 01-р сарын 27-ны өдрийн 21-р тушаалын 1 дүгээр хавсралт
2	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалын хавсралт

#### 9.2.3. Стандартууд

##### Монголын улсын стандартууд

1. “Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага” MNS 5344 - 2011
2. “Агаарын чанар. Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөв” MNS 6342- 2012 5х

##### Олон улсын стандартууд

- ЕХ-ны хог хаягдлыг ландфилл хийх тухай захирамж 99/31/ЕС (1999 он);
- ЕХ-ны хог хаягдлыг шатаах устгах тухай захирамж 2000/76/ЕС (2000 оны 12 сарын 4- ны өдөр);

- ДЭМБ-ын Эрүүл мэндийн салбарын аюулгүй хог хаягдлын менежмент: Бодлогын баримт бичиг, бүртгэлийн хуудас № 281, (эрүүл мэндийн салбарын хог хаягдлын менежмент);
- Аюултай хог хаягдлын хил дамжсан хөдөлгөөний хяналтын тухай конвенци, хог хаягдлыг устгах конвенци (Базелын конвенци, Монгол улс 1997 онд нэгдсэн);
- US EPA стандартууд CFR 258 (Хотын хатуу хог хаягдлыг ландфилдэх шалгуур) төсөлд хэрэгжүүлэхээр баталсан;

#### **9.2.4. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ ба менежментийн хяналт**

Хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулахын тулд нөлөөлөл бууруулах арга хэмжээ болон менежментийн хяналтыг барилгын ажлын үед хэрэгжүүлнэ. Гэрээт гүйцэтгэгчид нь доорх хүснэгтэд тодорхойлсон арга хэмжээнүүдийг өөрсдийн ажлын дүрэм журамд тусган дагаж мөрдөнө. Мөн туслан гүйцэтгэгчийн төлөвлөгөөнүүдэд доор дурдсан шаардлагуудыг дагаж мөрдөхөөр оруулж өгсөн байх ёстой.

Цаашилбал, олон улсын төсөл санхүүжүүлэгч байгууллагуудын байгаль орчны ерөнхий шаардлагад Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулан гаргасан байхыг шаарддаг бөгөөд агуулга нь дараах байдлаар тодорхойлогдсон байна. Үүнд:

- Зохицуулалтын шаардлагууд болон ангилал;
- Хариуцах талууд;
- Гарч болзошгүй хог хаягдлын төрөл, хэмжээ;
- Хог хаягдал үүсэхээс зайлсхийх болон бууруулах арга хэмжээнүүд;
- Хог хаягдлыг дахин ашиглах арга хэмжээнүүд;

Хог хаягдал үүсгэхгүй байх, бууруулах, газар дээр нь дахин ашиглах боломжгүй үед хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах, устган зайлуулах цэг зэргийн сонголтуудыг хийх;

Хог хаягдлыг тээвэрлэхээс өмнө цуглуулах, тээвэрлэх, хаягжуулах, түр хадгалах газруудыг сонгох;

Аюултай хог хаягдлын менежментийн тодорхой арга хэмжээнүүдтэй байх;

Хог хаягдлын тээвэрлэлтийн замыг тодорхойлох, баримтжуулах системийг бий болгох замаар хог хаягдлын шилжилтийг бүртгэх горимтой болох;

Ажилчид болон гэрээт гүйцэтгэгчдийг мэдлэг дээшлүүлэх сургалтад хамруулах.

“Улаан дэл услалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн арга хэмжээ**

№	Төслөөс үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
1	Ахуйн хатуу хаягдлаар орчныг бохирдуулах	Барилгын ажил явагдах талбайд ахуйн хатуу хог хаягдлыг хуримтлуулах битүүмжлэл сайтай, битүү тагтай, хогийг 4-5 төрөлд ангилан ялгах түр цэг болон хогийн савнуудыг байршуулах	Барилгын ажил эхлэх үед (2022 оны 1-р улиралд)	1250.0	Хог хаягдлын тухай хууль, 2017 он Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/349 дугаар тушаал,
2		Дахин боловсруулах боломжгүй ахуйн хаягдлыг 7 хоногт нэг удаа сумын хог хаягдлын төвлөрсөн цэгт зөөвөрлөх	7 хоног тутамд 1 удаа	400.0	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/443 тушаал, Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344 : 2011
3	Нэг удаагийн ахуйн хэрэглээ нь ахуйн хог хаягдлыг хэмжээг ихээр нэмэгдүүлнэ.	Нэг удаагийн ахуйн хэрэглээнээс татгалзах буюу нэг удаагийн аяга таваг болон бусад зүйлсийг огт хэрэглэхгүй байх, ахуйн хэрэглээний материалыг аль болох олон удаа ашиглах байдлаар үүсэж болох хаягдлыг бууруулах	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	Хог хаягдлын тухай хууль, 2017 он Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344 : 2011
4	Хог хаягдлыг ил задгай хаях замаар орчныг бохирдуулах	Барилгын талбайн орчимд ил задгай хог хаяхгүй байхыг нийт ажилчдад сайтар анхааруулах ба орчны хог хаягдлыг тогтмол түүж цэвэрлэх		-	Хог хаягдлын тухай хууль, 2017 он Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344 : 2011
5		Барилгын ажил дуусахад талбай дээр ямар ч хог хаягдал үлдээхгүй цэвэрлэж явах	Барилгын ажлын дараа (2023 он)	-	
6	Барилгын ажлыг төлөвлөлт муутай хийснээс үүсэх хаягдлын хэмжээ нэмэгдэнэ.	Ажлын хэмжээнээс хамаарч ашиглах материалын орц найрлага, хэмжээг зөв тохируулан аль болох хаягдал үүсгэхгүй байх, хаягдлыг хамгийн бага байхаар төлөвлөж ажиллах	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	Хог хаягдлын тухай хууль, 2017 он Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 48 дугаар тушаал, Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам

**“Улаан дэл усалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Төслөөс үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
7	Барилгын материалын томоохон хаягдлыг ил задгай хаясанаас	Үүссэн хаягдлыг дахин ашиглах боломж бололцоог судлах, ашиглаж болохуйц зуурсан шавар, бетон, модон болон төмөр эдлэхүүн зэрэг хаягдал, үлдэгдэл материалуудыг орон нутгийн иргэдэд буюу хэрэглэх хүнд нь өгөх	Барилгын ажлын үед (2023 он)	-	
8	орчныг бохирдуулахаас гадна мал амьтан бэртэж гэмтэх, тухайн хэсгийн ургамлан нөмрөгийн ургалт зогсох	Үүссэн хаягдлыг нэг цэгт бага талбайг хамруулан түр хадгалах арга хэмжээ авах	Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед (2023 он)	-	
9		Барилгын материалын хаягдлууд нь гол төлөв аюултай шинж чанар багатай байх тул энгийн хаягдлын хамтаар орон нутгийн төвлөрсөн хаягдлын цэгт 7 хоногт 1-2 удаа зайлуулах арга хэмжээ авах	Барилгын ажил эхэлснээс хойш 7 хоногт 1-2 удаа	1000.0	Хог хаягдлын тухай хууль, 2017 он Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 48 дугаар тушаал, Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам
10	Аюултай хаягдлыг ил задгай хадгалсанаас үүдэлтэй хөрс, ус хүнд металаар бохирдох, агаарт ууршилт явагдах, тэсэрч дэлбэрэх, мал амьтан хордох эрсдэлтэй.	Машин механизмын ашиглалт, засвар үйлчилгээний үед гарах бензин, тос, шатах тослох материалын үлдэгдэл, сав баглаа боодол зэрэг аюултай хаягдлуудыг түр хадгалах тусгай зориулалтын агуулах байгуулах ба агуулах нь бохирдуулагч бодис хөрсөнд нэвчихээс сэргийлсэн гадаргуутай, нарны шууд тусгал, галын эх үүсвэрээс тусгаарлагдсан битүүмжэл сайтай байна. Хуримтлагдсан аюултай хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх ба энгийн хаягдалтай хамт хаяхыг хориглоно.	Барилгын ажлын үед (2023 он)	Төслийн барилгын ажлын зардалд хамаарна.	Хог хаягдлын тухай хууль, 2017 он Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 2016 он Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 02 – ны өдрийн 116 дугаар тогтоол, Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам (Хавсралт 1), Аюултай хог хаягдлын жагсаалт (Хавсралт 2) Монгол Улсын Байгаль орчны сайдын 2003 оны 07 дугаар сарын 01- ний өдрийн 127 дугаар тушаал, Аюултай хаягдлын хадгалалт, устгалын бүртгэл

**“Улаан дэл усалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Төслөөс үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Зардлын төсөв, мян.төг	Баримтлах хууль, норм стандарт, аргачлал
11	Аюултай хаягдлыг ил задгай хадгалсанаас үүдэлтэй хөрс, ус хүнд металлаар бохирдох, агаарт ууршилт явагдах, тэсэрч дэлбэрэх, мал амьтан хордох эрсдэлтэй.	Аюултай хаягдал түр хадгалах агуулахыг тогтмол цоожтой байлгах ба хадгалж буй хаягдлуудын хор аюулын шинж чанарыг илтгэх анхааруулах тэмдэг тэмдэглэгээнүүдийг байршуулсан байна.	Барилгын ажлын үед (2023 он)	300.0	хөтлөх, мэдээ гаргах заавар (Хавсралт 1), Аюултай хог хаягдлын хадгалалт ба устгалын бүртгэл (Хавсралт 2)
<b>Дүн (Хог хаягдал)</b>				<b>2950.0</b>	

## АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагаанаас орчны агаар, ус, хөрсөнд үзүүлэх нөлөөллийг илрүүлэх, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, сөрөг нөлөөллийг бууруулах талаар авсан арга хэмжээний дүнг хянаж шалгах, цаашдын үйл ажиллагааг тодотгох зорилгоор хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

ОХШХ-т төсөл хэрэгжих газрын агаарын чанар, усны чанар, хөрсөн бүрхэвч, дуу чимээний нөлөөлөл зэрэг хяналт шинжилгээний үзүүлэлт, хэмжилт хийх, дээж авах байршил, хугацаа, давтамж, холбогдох стандарт болон эдгээр ажлыг гүйцэтгэхэд шаардагдах зардлын төсвийг тооцоолов.

ОХШХ-ыг байгаль орчны мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар хэрэгжүүлж, хяналт тавьж, тухайн бүрт нь тайлагнан ажиллана.

Улаан дэл услалтын системийн байгууламжийн барилгын ажлын үед авч хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт **1,630.5 мян.төг** зарцуулахаар тооцоо гарсан. Ингэхдээ итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний тарифийг үндэслэл болгов.

### Хүснэгт 8. Лабораторийн шинжилгээний тариф

№	Шинжилгээний төрөл	Үнэ, ₮	Хэмжилт хийх хугацаа
1	Агаарын чанарын шинжилгээ (SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , CO)	73,500	5, 9 сард
	Тоосны үзүүлэлт (PM10, PM2.5, TSP)		
2	Хөрсний ерөнхий шинжилгээ (Агрохими, Механик бүрэлдэхүүн)	25000	
	Хөрсний бохирдлын шинжилгээ (1 дээжид 6 элемент: Ni, Cu, Cr, Cd, Pb, Zn)	25000	
	Хөрсний бактерлогийн шинжилгээ	25000	
3	Ундны усны бүрэн шинжилгээ (ерөнхий хими)	72000	
	Усны бохирдлын шинжилгээ (1 дээжид 6 элемент Cu, Ni, Co, Cr, Pb, Ag)	78000	
	Усны бактерлогийн шинжилгээ	49700	

**“Улаан дэл усалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**Хүснэгт 9. “Улаан дэл усалтын систем”-ийн барилгын ажлын үед авч хэрэгжүүлэх 2023 оны ОХШХөтөлбөр**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардйал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
<b>1. АГААРЫН ЧАНАР</b>								
1.	Агаарын чанарын (NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , PM <sub>2.5</sub> , PM <sub>10</sub> ) шинжилгээ хийлгэж байх	барилгын ажлын талбайд - Салхин доод талд 20-40 м-ийн бүсэд	3 цэгт 5, 9 сард	3 цэгт * 2 сар = 6 удаа	73,500.0 + 25,000.0 техникч томилолт	491.0	Баян-Өлгий аймгийн УЦУОШГ-ын лабораторийн техникчийн хамт гүйцэтгэнэ.	- MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга
2.	Тээврийн хэрэгслийн хаягдал утааны хяналт шинжилгээ	1. Бензин хөдөлгүүртэй 2. Дизель хөдөлгүүртэй автомашин бүрд	Барилгын ажил эхлэхээс өмнө	1	45,000.0	45.0	Хөдөлгөөнд оролцоогүй үед зөөврийн багажаар - 10000 Хөдөлгөөнд оролцож буй үед иж бүрэн хэмжлийн багажаар тасралтгүй хэмжих- 35000	- MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ хэвийн норм, төвшний хэмжээ - MNS 5013:2009 Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ
3.	Дуу шуугиан, чичиргээний хэмжилт хийх	Агаарын чанарын хяналтын цэгүүд болон ажлын талбаруудад цэг тогтооно.	Сард нэг удаа	9	-	-	Өөрсдийн багажаар тогтоосон ажлын байруудад ба цагт стандартад заасан хугацаанд хийх	- MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга
<b>2. ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УСНЫ ЧАНАР</b>								
1	Усны ерөнхий химийн үзүүлэлтүүд	Ажилчдын унд ахуйн худаг	5, 9 сард	2	72,000.0	144.0	Шинжилгээний үр дүнг мэргэжлийн хөндлөнгийн лаборатори хянах нь зүйтэй.	MNS 4586:98 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага, MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүйн байдал.



**“Улаан дэл усалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

								Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага. Чанар, аюулгүй байдлын үнэлгээ,
		Сагсай гол	5, 9 сард	2	72,000	144.0		
2	Гадаргын болон газрын доорх усны бохирдлын хяналт хийх/ 20 элемент/	Ажилчдын унд ахуйн худаг	Жилд 1 удаа	1	78,000.0	78.0		MNS 6148:2010 Усны чанар. Газар доорх усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
		Сагсай гол	Жилд 1 удаа	1	78,000.0	78.0		
3	Усны мэргэжлийн байгууллагаар голын урсац, горимын хэмжилт судалгааг хийлгэх	Сагсай гол	Жилд 1 удаа	Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах				
<b>3. ХӨРС, ХӨРСӨН БҮРХЭВЧ</b>								
1	Хөрсний ерөнхий шинжилгээ (Агрохими, Механик бүрэлдэхүүн)	Барилгын талбайн эргэн тойронд	Барилгын ажил эхлэхийн өмнө, дууссаны дараа, нийт 2 удаа	5 цэгт * 2 удаа= 10	25,000	250.0	Шинжилгээний үр дүнг мэргэжлийн хөндлөнгийн лаборатори хянах нь зүйтэй.	MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS 6147 : 2010 Байгаль орчны бохирдол, бохирдлын хяналт ба хамгаалалт - Агаар, хөрсөн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS ISO 10382 : 2012 Хөрсний чанар. Органик хлорт пестицид ба полихлорт бифенилийн агууламжийг электрон баригч детектор бүхий хийн хроматографиар тодорхойлох арга
2	Хөрсний хүнд металлын шинжилгээ Cd/кадми/, Pb/хартугалга/, Cr/хром, Zn /цайр/, Cu /зэс/, Ni /никель/	Барилгын талбайн эргэн тойрон болон машин механизмын зогсоолын талбайгаас	5, 9 сард	5 цэгт * 2 сар= 10	25,000	250.0		

**“Улаан дэл услалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

<b>3</b>	Нянгийн бохирдол: • (1гр-д) Колититр • Cl.perferringens титр	Хаягдлын цэгүүд, ажилчдын бие засах газрын орчмоос	5, 9 сард	3 цэгт * 2 сар= 6	25,000	150.0		
<b>Хяналт мониторингийг хэрэгжүүлэх гүйцэтгэлийн зардал</b>								<b>1,630.0 мянган төгрөг</b>

## АРВАН НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ, ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Аливаа байгууллагын байгаль орчны асуудлыг хариуцах, удирдан зохион байгуулах бүтэц нь ISO 14001 2004 (MNS 2006) стандартад заасан Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) бөгөөд үүнд тухайн байгууллагын байгаль орчны бодлогын хүрээнд төлөвлөх хэрэгжүүлэх-хянах-шийдэх гэсэн 4 үйл ажиллагаа тасралтгүй хийгдэж байгаль орчны үзүүлэлт байнга сайжирч байх нөхцөлийг бүрдүүлдэг. Менежментийн тогтолцоонд байгууллагын бүтэц, төлөвлөлт, хариуцлага, практик үйл ажиллагаа, бодлого, дүрэм журмын баримт бичиг, процесс, нөөцийг хамааруулдаг (ISO 14001, 2004).

БОУТ-ны бүрдэл хэсэг, үйл ажиллагааны товч тайлбар:

Байгаль орчны бодлого: Тухайн байгууллагын байгаль орчны үзүүлэлтийн талаар дээд удирдлагаас тогтоосон зорилт, чиглэл юм.

Төлөвлөлт: Байгаль орчны асуудал, хууль журам, стандартын шаардлага, байгаль орчны талаар баримтжуулж, баталгаажуулсан зорилго, зорилт, хөтөлбөр;

Хэрэгжүүлэлт: Хүн, материал, технологи, дэд бүтэц, санхүүгийн нөөц, үүрэг, хариуцлага, захиргаа, ажиллагсдын мэдлэг чадвар, сургалт, харилцаа холбоо, байгаль орчны баримт бичиг болон үйл ажиллагааны хяналт, удирдлага, онцгой нөхцөлийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах ажиллагаа;

Хяналт, сайжруулалт: Хяналт шинжилгээ, хэмжилт, гүйцэтгэлийн шалгалт, дутагдал, доголдлыг засах, сайжруулах, сэргийлэх, бүртгэлийн хяналт удирдлага, дотоод аудит;

Удирдлагын хяналт: Байгууллагын дээд удирдлагын зүгээс тогтмол хугацаанд хийх хяналт шалгалтын үйл ажиллагаа, байгаль орчны бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийн үзүүлэлт, үр дүнг хянана.

“Улаан дэл услалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**Хүснэгт 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын зардал**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хувиар						Хариуцсан албан тушаалтан	тайлбар	
			2023								
			4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар			10 сар
1	Үйл ажиллагаа, онцлогт тохируулан ХАБЭА болон БО-ны бодлого дүрэм журмыг боловсруулан ажилчдад танилцуулах.	Үйл ажиллагааны зардалд тусган хэрэгжүүлэх	+							ХАБЭА инженер, БО-ны мэргэжилтэн	Барилгын ажил гүйцэтгэгч компани хариуцан хэрэгжүүлэх
2	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлөөр хангах.		+								
	Аюулгүй ажиллагааны дүрэм журмыг баримтлан ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих, уг ажлын хүрээнд ажлын байрны үзлэг хийх.		+								
3	Барилгын талбайн байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод хяналтын хуудас бөглөн, алдаа, зөрчлийг залруулах, арилгуулах ажлыг хэрэгжүүлж байх		+								
4	Услалтын системийн байгууламжийг батлагдсан зураг төслийн дагуу барьж байгуулах.				+				Төслийн удирдагч		

**“Улаан дэл усалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хувиар						Хариуцсан албан тушаалтан	тайлбар
			2023							
			4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар		
5	Төслийн зүгээс байгаль орчин, нийгэм эдийн засгийн зохистой үзүүлэлтийг хангах, төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдлыг нь барагдуулах зорилгоор гомдол барагдуулах менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх;								Олон нийттэй харьцах мэргэжилтэн	
7	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх									
8	Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөө, биелэлтийн талаар орон нутгийн удирдлага болон ард иргэдтэй уулзалт зохион байгуулж, тайлагнах.								+	
<b>Нийт зардал</b>		-								

**АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй сөрөг нөлөөллийн талаарх мэдээллийг оролцогч талуудад нээлттэй байх гэсэн зарчмын дагуу төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, орон нутгийн удирдлага болон холбогдох бусад байгууллагын төлөөлөл багтсан оролцогч талуудад төслийн үйл ажиллагаа, БОМТ, түүний биелэлтийг тайлагнах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал авах зорилгоор дараах арга хэмжээг төлөвлөсөн ба тус арга хэмжээнд төсөвлөсөн.

Төсөл хэрэгжих хугацаанд Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагааны үе шат бүрт дээрх субъектүүд тодорхой хэмжээнд оролцож, хэрэгжилтэнд хяналт тавиж, шийдвэр гаргана.

**Хүснэгт 11. Гүйцэтгэлийн шатны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь**

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
<b>Иргэд олон нийт/дурын оролцогч, сонирхогч талууд</b>	Санал, хүсэлт хүлээн авч төсөлтэй холбогдох гомдлыг барагдуулах	Байгаль орчны талаар тавьсан санал гомдолтой холбогдол бүхий бүх төрлийн мэдээлэл	Төсөл хэрэгжих бүх хугацааны турш	Сонирхогч оролцогч талуудыг хүссэн мэдээллээр хангах	Төслийн талбай, сумын иргэдийн хурлын танхим
<b>БОАЖЯ</b>	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан БОАЖЯ-аар батлуулна.	Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, энэхүү байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бүүруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн зөвхөн тухайн жилд хийгдэх ажлуудын төлөвлөгөөг боловсруулсан байна.	Жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны тухайн жилийн БОМТ-г батлуулна.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.	-
<b>Аймгийн байгаль орчны газар</b>	Тухайн жилийн байгаль орчны менежментийн	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг	Жил бүрийн 11 дүгээр сарын	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайланг газар дээр нь хянаж, дүгнэх ажлын	-

**“Улаан дэл услалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
	<p>төлөвлөгөөний биелэлтийн тайланг аймгийн байгаль орчны газарт хүргүүлнэ.</p>	<p>тусгасан биелэлтийн тайлан боловсруулан хүргүүлнэ.</p>	<p>01-ний дотор аймгийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.</p>	<p>хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулах ба ажлын хэсэг тухайн жилийн БОМТ-ний биелэлтийг газар дээр нь шалгаж, дүгнэх ажлыг 11 дүгээр сарын 30-ны дотор зохион байгуулж, оноогоор дүгнэнэ. Ажлын хэсгийн үнэлсэн нэгдсэн дүн 90 онооноос дээш гүйцэтгэлтэй байвал төсөл хэрэгжүүлэгчээс боловсруулж ирүүлсэн дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлах нэг нөхцөл болно.</p>	

**АРВАН ГУРАВ. БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДАЛ**

**Хүснэгт 12. БОМТ арга хэмжээний зардлын товчоо**

<b>БОМТ 2023</b>	<b>Төсөв, мян.төг</b>
Барилгын болон үйл ажиллагааны үед байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,800.0
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	25000.0
Осол эрсдэлийн менежмент	1,250.0
Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,850.0
БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	-
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1,630.0
<b>Нийт төсөв</b>	<b>31,530.0</b>



## НОМ ЗҮЙ

1. “Улаан дэл услалтын систем” төслийн БОННУ-ний тайлан, 5 жилийн БОМТ, “Грийн натур ланд” ХХК, “Экос” ХХК, “Нью грийн ворлд” ХХК 2021
2. АХБ-ын Хамгааллын бодлогын баримт бичиг, 2005
3. АХБ-ны Барилгын үйл ажиллагаа эхлэх үед баримтлах заардлага
4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, БОАЖС-ын тушаал, 2013
5. ISO 14001, 2004: ISO (MNS) 14000, Байгаль орчны тогтолцоо, 2004
6. [www.mne.mn](http://www.mne.mn)
7. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
8. [www.nso.mn](http://www.nso.mn)
9. [www.estandard.mn](http://www.estandard.mn)

## ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын жагсаалт

Хавсралт 2. Санал хүсэлт, гомдол мэдүүлэх маягт

Хавсралт 3. ХАБЭАБО-ны бодлогын бичиг баримт

Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын жагсаалт

### Монгол улсын хуулиуд

- “Агаарын тухай хууль”, 2012 он
- “Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль” 2010 он
- “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”, 2012 он
- “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, 1995 он
- “Галын аюулгүй байдлын тухай” хууль, 2015 он
- “Усны тухай хууль” 2012 он
- “Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хууль” ,2012 он
- “Ургамал хамгааллын тухай хууль”, 2007
- “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль” 2008 он
- “Хог хаягдлын тухай хууль”, 2017 он
- “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль”, 2012 он
- “Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль”, 2015 он

### Монгол улсын стандарт

№	Байгаль орчин	
1	MNS 4585 :2016	Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага
2	MNS 5850 :2019	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3	MNS 5917 :2008	Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
3	MNS 5818 :2008	Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах.Техникийн ерөнхий шаардлага
4	MNS 5914 :2008	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо.
5	MNS 5916 - 2008	Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт , хадгалалт
6	ISO 5667-1	Water quality, Sampling (Guidance on the design of sampling programmes and sampling techniques)
7	MNS 6148 :2010	Усны чанар. Газар доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
8	MNS 3342 - 1982 2 х	Байгаль орчны хамгаалал, усан мандал Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага
9	MNS 5885 :2008	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
10	MNS 17.2.0.07 - 1979	Байгаль орчныг хамгаалах. Агаарыг бохирдуулах хаягдал. Ангилал
11	MNS 3474 - 2003	Ургамал хамгаалал. Нэр томьёо, тодорхойлолт
12	ISO 5667-3 20012/11/15	Water quality Sampling (Part3 Preservation and handling of water samples)

**“Улаан дэл услалтын систем” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

13	ISO 14403-2 2012/7/15	Water quality Determination of total cyanide and free cyanide using flow analysis (FIA and CFA), Part2 Method using continuous flow analysis (CFA)
14	MNS ISO 14001 2005	Байгаль орчны удирдлагын тогтолцоо, шаардлага хэрэглэх арга зүйн заавар
15	MNS ISO Guide 64 2011	Бүтээгдэхүүний стандартад байгаль орчны асуудлыг тусгах тухай арга зүйн удирдамж
<b>Хөдөлмөр хамгаалал</b>		
1	MNS 5002 :2000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
2	MNS 5247 :2003	Барилга байгууламжийн гал унтраах ус түгээгүүрийн цогцолбор. Техникийн ерөнхий шаардлага
3	MNS 5566 :2005	Гал түймрээс хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага
<b>Эрүүл ахуй</b>		
1	MNS 900 :2018	Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүйн байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага. Чанар, аюулгүй байдлын үнэлгээ
2	MNS 4946 :2005	Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ Хоолны газрын ангилал зэрэглэл. Ерөнхий шаардлага

Санал хүсэлт, гомдол мэдүүлэх маягт

Дугаар	
Огноо:	<i>Он сар өдөр</i>
Өргөдөл, гомдол гаргагчийн овог, нэр	
Өргөдөл, гомдол гаргасан хүний оршин суугаа хаяг:	<i>Аймаг, сум, баг/тосгон, газрын нэрийг бичих</i>
Утас (гар):	
Утас (гэрийн):	
Имэйл хаяг:	
Өргөдөл, гомдол гарган болсон асуудал (юу тохиолдсон бэ?):	
Хэзээ болов:	<i>огноо</i>
Давтамж:	<i>Өдөр тутам/долоо хоног бүр/сар бүр</i>
Хаана (гомдол гаргах асуудал хаана гарсан):	<i>Аймаг, сум, баг/тосгон, газрын нэрийг бичих</i>
Хэн оролцсон:	<i>Нэр/албан тушаал, тодорхойлолт (хэрэв мэдэж байгаа бол)</i>
Энэ асуудал нь компанид яагаад хамааралтай бэ:	
Таны санал болгож буй/хүсч буй шийдэл	
Зөвхөн албан хэрэгцээнд:	
Гомдол хүлээн авсан компанийн ажилтан:	<i>Нэр/албан тушаал</i>
Шийдвэрлэсэн нь – ХҮЛЭЭН	Ангилал:
АВСАН НЬ:	Дараагийн алхмууд:
Шийдвэрлэсэн нь – ТАТГАЛЗСАН:	Шалтгаан:
Өргөдөл, гомдол гаргасан хүний гарын үсэг:	
Хүлээн авсан ажилтны гарын үсэг:	

УЛААН ДЭЛ УСЛАЛТЫН СИСТЕМИЙН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖИЛД ДАГАЖ  
МӨРДӨХ ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Энэхүү норм ба дүрмийг барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөж шинэчлэх, сэргээн засварлах, техникийн шинэчлэлт болон их засвар хийх (цаашид барилгын үйлдвэрлэл гэх) барилгын материалын үйлдвэрлэл, машин механизм, тоног төхөөрөмжийн аж ахуй, түүнчлэн барилгын бүтээц, эдлэхүүний үйлдвэрлэл эрхлэн гүйцэтгэдэг бүх байгууллага, аж ахуйн нэгжүүд харьяалал, өмчийн хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө. Барилга угсралтын талбайд хамтран ажиллах ерөнхий гүйцэтгэгч, түслан гүйцэтгэгч, түншлэлээр болон гэрээгээр ажил гүйцэтгэгч байгууллагууд барилга угсралтын талбайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин, галын аюулгүй байдлын норм норматив, стандартуудыг энэ талбайд ажиллах байгууллага бүр өөрсдөө жигд мөрдөн ажиллах хэрэгтэй. ҮҮНД: **MNS OHSAS-18001:2012** хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ерөнхий шаардлага. **БД 12-105-07** барилгын материал үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн дүрэм. **БД 12-101-05** Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн заавар, **БНБД 12.03.04** Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, **БНБД 12.04.06** Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, **БД 12-106-14** Ажлын байрны зааварчилгаа өгөх аргачилсан зөвлөмж, **БНБД 21-01-02** Барилга байгууламжийн галын аюулгүй байдал, **БНБД 12-01-03** барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт, **MNS 5414:2004** барилгын талбайн түр хашаа, **MNS 5415:2004** барилгын талбайн зохион байгуулалтын зургийн тэмдэглэгээ, **MNS 00112-4-00:85** сануулах ба хориглох тэмдэг, **MNSISO13688:2000** ажлын тухай хувцас, Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн зааварчилгааг зэргийг мөрдөн ажиллана.

Барилгын ХАБЭА-н бүхий л ажилд орчин үеийн мэдээлэл холбооны хэрэгслийг заавал хэрэглэж ХАБЭА-н ажлыг камерын бичлэг, фото зураг зэрэг мэдээллийн сангаар баталгаажуулах, ХАБЭА-н зааварчилгаа, сургалтыг кино, чанга яригч ашиглаж хийх, ХАБЭА-н ажлыг хянаж удирдах дотоодын мэдээллийн шүүрхай сүлжээг буй болгож энэ ажлыг техникийн дэвшлээр удирдах нь барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч байгууллага бидний гол зорилт болно. Барилга угсралтын талбайд ажиллаж буй талбай хариуцсан инженерүүд өдөр бүр ажилчдад өгөх ХАБЭА-н зааварчилгааг тухайн өдөр хэн ямар ажил гүйцэтгэхээс нь хамааруулан хүн нэг бүрд тодорхой зааварчилгааг ажилд гарахын өмнө өгч гарын үсэг зуруулж ажилд нь оруулж байх.